



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

## **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**2020 ОН**

**УЛААНБААТАР ХОТ  
2020 он**

**АГУУЛГА**

Танилцуулга, бүтэц зохион байгуулалт

Хуудас 2-3

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн биелэлт
- Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт
- Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын 2020 онд хамтран ажиллах гэрээний биелэлт

Хуудас 4-5

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

- Засгийн газрын тогтоолын биелэлт
- Засгийн Газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлт
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын биелэлт
- Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт
- Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын биелэлт
- Нийслэлийн Засаг даргаас 2020 оныг “Нэг хот-Нэг стандарт” болгон зарласан ажлын биелэлт

Хуудас 5-6

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

- Дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт
- Хүний нөөцийн чадавхижуулалт, нийгмийн баталгаа
- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
- Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа
- “Нийслэлийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан”-д гаргасан тайлан мэдээ

Хуудас 6-36

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

- Үйл ажиллагааны ил тод байдал хүснэгтээр
- Хүний нөөцийн ил тод байдал хүснэгтээр

Хуудас 36-39

**ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ**

- Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажил
- Шинээр санаачилсан ажлууд
- Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт

Хуудас 39-54

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 68 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар байгуулагдан, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дүгээр захирамжаар тус газрын бүтэц орон тоог 12 хүнтэй үүнээс дарга -1 байхаар баталж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2009 оны 01 дүгээр тушаалаар ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн -9 албан хаагчтайгаар анх үйл ажиллагаагаа эхэлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай А/323 дугаар захирамжаар тус газрын бүтэц орон тоог нэмэгдүүлэн шинэчилж 18, үүнээс дарга 1 байхаар баталж, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-12 /ТЗ/, мэдээллийн төвийн менежер-1, мэдээллийн технологи хаируцсан инженер-1, архив, бичиг хэргийн эрхлэгч-1 /ТҮ/ албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

2016-2020 онд Нийслэлийн Засаг даргын 2016 оны Дүрэм батлах тухай А/831 дүгээр захирамжаар тус газрын дүрмийг шинэчлэн баталж, газрын дарга-1, орлогч дарга-1, Захиргааны хэлтэс-6, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс-5, Мэдээлэл, сурталчилгааны хэлтэстэй-5 буюу үндсэн ажилтан 18, Нийслэлийн Засаг даргын 2020 оны Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай А/283 дугаар захирамжийн дагуу хөдөлмөрийн гэрээгээр мэдээлэл, сурталчилгааны төвийн ажилтан-3, нийт 21 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж, Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн удирдлага, дэмжлэгээр хангах, нийслэл хотыг гадаад дотоодод сурталчлах, төрөөс аялал жуулчлалын чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэх замаар Улаанбаатар хотыг Зүүн хойд Азийн соёл, бизнес болон дамжин өнгөрөх аялал жуулчлалын төв болох нөхцөлийг бүрдүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав.

Байгууллагын үйл ажиллагааны тайланг Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу нэгтгэж тайлагнав.

### **АЛСЫН ХАРАА:**

Аялал жуулчлалыг нийслэл хотын эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилд шийдвэрлэх үүрэг бүхий салбар болгон хөгжүүлнэ.

### **ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Нийслэл Улаанбаатар хотыг гадаадын жуулчин хүлээн авах хүчин чадал, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий хот болгон хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлнэ.


### **ХАМРАХ ХҮРЭЭ:**

Нийслэлийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчид, аялал жуулчлалтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагууд.

### **ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД:**

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сайжруулах, шинээр бий болгох
2. Жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх, жуулчны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах
3. Улаанбаатар хотын гадаад сурталчилгааг явуулж, зорих газрын менежментийн бодлого, маркетингийн стратегийг хэрэгжүүлэх
4. Жуулчдыг татах төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах, аялал жуулчлалын эдийн засаг, нийгмийн нөлөөллийг зохистой хэмжээнд байлгахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах
5. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх
6. Жуулчид, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад зориулсан төрөл бүрийн сургалт, судалгааны ажлууд зохион байгуулах
7. Нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр санаачлан хэрэгжүүлэх

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ  
АГЕНТЛАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нэг. Монгол Улсын “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийслэлийн Аялал жуулчлалын газраас хэрэгжүүлэхээр 4 зорилтын 6 арга хэмжээ тусгагдсан. Тайлант хугацаанд 5 арга хэмжээ 100%, 1 арга хэмжээ 70% нийт хөтөлбөрийн 95%-тай байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хэрэгжилт		
<b>Нийт арга хэмжээний тоо</b>		<b>6</b>
1. Бүрэн хэрэгжсэн	100 хувь	5
2. Хэрэгжих шатанд	70 хувь	1
3. Хэрэгжилт хангалтгүй	40 хувь	-
4. Хэрэгжээгүй	0 хувь	-
5. Хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй	-	-
<b>Биелэлтийн хувь</b>		<b>95 хувь</b>

Хоёр. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд нийт 5 зорилт, 29 арга хэмжээний 63 ажлыг хэрэгжүүлэхээс 62 ажлыг хийж, 1 ажлыг үнэлэх боломжгүй, нийт хэрэгжилт 100 хувийн үр дүнтэй байна.

Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөрийн хүрээнд тус газар нь нийт 2 зорилтын 2 арга хэмжээний нийт 18 ажлыг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилт 100 хувьтай байна.

Гурав. Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус газраас хариуцан хэрэгжүүлэх 9 заалт тусгагдсан. 2020 оны байдлаар 9 заалтыг 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт		
<b>Нийт заалтын тоо</b>		<b>9</b>
1. Бүрэн хэрэгжсэн	100%	9
2. Хэрэгжих шатанд	70%	-
3. Хэрэгжилт хангалтгүй	40%	-
4. Хэрэгжээгүй	0%	-
5. Хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй	-	-
<b>Биелэлтийн хувь</b>		<b>100%</b>

Дөрөв. Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тус газраас хариуцан хэрэгжүүлэх нийт 14 арга хэмжээ 93.3%-тай байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

Нийслэлийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн дүн	
<b>Нийт арга хэмжээний тоо</b>	<b>14</b>

Бүрэн хэрэгжсэн	100%	7
Хэрэгжих шатанд	70%	2
Хэрэгжилт хангалтгүй	40%	-
Хэрэгжээгүй	0%	-
Хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй	-	5
Үүнээс:Хугацаа болоогүй		-
Үнэлэх боломжгүй		5
<b>Үнэлгээний хувь</b>		<b>93.3%</b>

Тав. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарын 2020 онд хамтран ажиллах гэрээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2020 онд хамтран ажиллах гэрээнд 5 зорилтын 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан. 2020 оны байдлаар хэрэгжилтийг 81.2 хувьтай ханган ажилласан байна.

Нийт 5 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 2020 оны байдлаар 93.3%-тай ханган ажилласан байна.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

#### А/. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт.

Байгууллагын хэмжээнд 2020 оны байдлаар 24 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нийт 44 заалтын ажлыг хяналтандаа авч ажилласан байна. давхардсан тоогоор 24 шийдвэрийн 44 заалтын хэрэгжилтийг 89 удаа тайлагнаж ажиллав.

Төрлөөр нь авч үзвэл:

Заалт	Нийт	Засгийн газрын тогтоол	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл	Нийслэлийн Засаг даргын Захиармж	Нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	24	1	1	3	13	6
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	44	11	1	3	18	11
Бүрэн хэрэгжсэн	100%	9		3	18	11
Хэрэгжих шатандаа	70%	1	1			
Хэрэгжилт хангалтгүй	30%					
Хэрэгжээгүй	0%					
Хэрэгжилтийг хугацаа болоогүй /үнэлэх боломжгүй/ тооцох	1	1				
<b>Биелэлтийн дундаж</b>	<b>98,5%</b>	<b>97%</b>	<b>70%</b>	<b>100%</b>	<b>100%</b>	<b>100%</b>

Цаашид эрчимжүүлэх шаардлагатай заалтууд: Үүнд:

1. “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” МУ-ын Засгийн газрын 2018 оны тогтоолын 1.2 заалт “Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх”

2. “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 01 дүгээр тогтоолын 1.3 заалт “Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээний цэгүүд, барилга байгууламжуудын харуул хамгаалалтын байр, аялал зугаалга, амралт сувиллын газруудын зуухыг цахилгаан халаалтад бүрэн шилжүүлэх ажлыг 2018 оны II улирлаас хэрэгжүүлэх” зэрэг ажлууд байна.

**Б/. Зорилтот жилийн хүрээнд:**


Нийслэлийн Засаг даргын 2020 оныг “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жил болгон зарлах тухай А/01 дүгээр захирамжийн дагуу зорилтот жилийн хүрээнд 4 чиглэлийн 9 хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган баталж, хэрэгжилтийг 100% ханган ажиллав.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

**А/. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ:**

**1. Аялал жуулчлалын байгууллага болон жуулчдад үйлчлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:**

➤ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын дагуу аж ахуйн нэгж байгууллагаас зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлтийн дагуу ажлын хэсэг стандартын үзлэг шалгалтыг зохион байгуулна. 2020 оны байдлаар тус газар стандартын шаардлага хангасан 233 зочид буудал, 164 дэн буудал, 64 амралтын газар, жуулчны баазад зөвшөөрөл олгов. Стандартын шаардлага хангаагүй байгууллагад заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.





**2. Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарын нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах ажлын хүрээнд:**


➤ **“Улаанбаатар травэл экспо-2020” цахим үзэсгэлэн зохион байгуулав.**

Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын мэдээллийг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын А/733 дугаар захирамжаар “Улаанбаатар травэл экспо-2020” цахим үзэсгэлэнг “Төлөвлөө, Аялъя, Суралцъя” уриан доор Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран зохион байгуулсан. Цахим үзэсгэлэнгээр аялал жуулчлалын салбарын 80 гаруй байгууллагууд оролцон бүтээгдэхүүн үйлчилгээ, аяллын багц, хөнгөлөлт урамшууллаа танилцуулан, 10-50% хөнгөлөлтийг иргэдэд үзүүлсэн ба 3 өдрийн турш цахим хэлэлцүүлэг, илтгэлүүдийг явуулсан. Цахим үзэсгэлэнгийн 3 өдрийн үйл ажиллагааг нийт 6 социал хаягаар шууд дамжуулалт хийж 56.800 гаруй иргэд үзэж сонирхсон байна. Үзэсгэлэнгийн үеэр “Жим аяллын хөтөч” сэтгүүлийг М+ аппликейшинд цахим хэлбэрээр үнэ төлбөргүй татан авах боломжтойгоор нийтэлсэн ба хэвлэмэл 500 ширхгийг гарган аялал жуулчлалын компани болон иргэдэд үнэ төлбөргүй тараасан. Цахим үзэсгэлэнгийн хэвлэлийн бага хурлыг 18 сувгаар зэрэг цацсан бөгөөд үзэсгэлэнгийн үеэр болсон хэлэлцүүлэг болон илтгэлийг 3 өдрийн турш 6 цахим мэдээллийн хэрэгслээр мэдээлж ажиллав.

Цахим үзэсгэлэнгийн ЛАЙВ-ын хандалт /пэйж болон өдөр тус бүрээр/

№	Пэйжийн нэр	05.29 өдөр		05.30 өдөр		05.31 өдөр	
		Reach	Views	Reach	Views	Reach	Views
1	НАЖГ	6,241	7,8K	4,188	8,8K	6,072	6,7K
2	УБАЖХ	13,954		23,593		12,135	
3	Mongolian Tourism News	693	7,8K	1028	8,8K	4068	6,7K
4	БОАЖЯ	125		197		195	
5	Creative Mongolia		2,7K		2,2K		5,3K

Цахим үзэсгэлэнгийн нээлт



Цахим үзэсгэлэнгийн хэлэлцүүлэг



➤ **“Улаанбаатар явган аяллын фестиваль” зохион байгуулав.**

Нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 381 жилийн ой, Монгол Улс, БНСУ дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн хүрээнд Монголын явган алхалтын холбоо, Монгол Оллэ нийгэмлэгтэй хамтран “Улаанбаатар явган аяллын фестиваль”-ийг 2020 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт 2 дахь жилдээ зохион байгуулав. Явган аялалд Монголын явган алхалтын холбоо, Хайрхан аялагч клуб, Мазаалай аялагч клуб, Хоризон хайкинг клубүүдийн төлөөлөл, Солонгос улсын алхагчид нийт 150 гаруй хүн оролцож, Монгол Оллэ маршрутаар 11 км алхав. Арга хэмжээний үеэр Солонгос, Япон улсуудад болж байгаа Хаврын явган алхалтын баярт зориулсан видео бичлэгийг хийж БНСУ-ын Жэжү хотруу илгээсэн. Оролцогчид Тэрэлж голын орчмын хогийг цэвэрлэж, Налайх дүүргийн хогийн цэгт 1 тонн хог төвлөрүүлэв. “Улаанбаатар явган аяллын фестиваль”-д оролцсон нийт алхагч нарт алхалтын замаа амжилттай дуусгасныг баталгаажуулан Хангардийн дүрс бүхий түлхүүрийн оосор, Хоггүй аялал гоё аяны авто машины түр зогсов тэмдэглэлийг дурсгаж, Налайх дүүргийн 6-р хорооны иргэд цагаан идээ ааруул, гар урлалын бүтээгдэхүүн танилцуулж, морь унуулах үйлчилгээ үзүүлэв.



➤ **“E-bus city tour” сурагчдад зориулсан хотын аялал зохион байгуулав.**

Нийслэлийн Аялал жуулчлалын газар, нийслэлийн Боловсролын газар, “Соёлын солилцоо, хөгжлийн төв” ТББ-тай хамтран нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 381 жилийн ойг угтан “E-bus city tour” сурагчдад зориулсан хотын аяллыг 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав. Аяллын хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 10,11 дүгээр ангийн сурагчдын дунд “Хог хаягдал ба хотын соёл” сэдэвт англи хэл дээрх эсээ уралдааныг 10 дугаар сарын 05-10-ны өдрүүдэд зарлаж, уралдаанд 50 гаруй сургуулийн 200 гаруй сурагчид эсээ бичиж ирүүлснээс шилдэг 40 сурагчийн эсээг шалгаруулж, шалгарсан сурагчдыг хотын бүтэн өдрийн эко автобустай аялалд хамрууллаа. Аяллыг нийслэлийн Аялал жуулчлалын газрын Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв, жанжин Д.Сүхбаатарын талбай, Улаанбаатар хотын музей, “Сан оргиу” ХХК, “Од пластик” ХХК, Занабазарын нэрэмжит дүрслэх урлагийн музейд гарч буй “Хүн+С” үзэсгэлэн гэсэн маршрутын дагуу зохион байгуулсан ба аяллаар Улаанбаатар хотын үүсэл хөгжил, хотын түүхэн дурсгалт барилга байгууламж, хөшөө дурсгал, хотын соёлын талаар болон хог хаягдлын эх үүсвэр, дахин ашиглалт, боловсруулалтын талаарх мэдээ мэдээллийг өгөв. Аялалд оролцсон сурагчдад Батламж гардуулсан ба эсээ уралдаанд хог хаягдлыг бууруулах шилдэг санаа бичиж ирүүлсэн шилдэг 3 сурагчийг нийслэлийн “Шилдэг хүүхэд” алтан медалиар шагнаж урамшуулав.



➤ **“Хотын соёл” аянд нэгдэв.**

Нийслэлийн Соёл урлагийн газраас зарласан “Хотын соёл” аянд нэгдэн Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх түүх, соёлын хөшөө баримал, сүм хийд, археологийн дурсгалт газруудыг иргэд, олон нийтэд сурталчлах, тэдгээрийг сэргээн засварлах, арчлан хамгаалах, өнгө үзэмжийг сайжруулах, хотын соёлыг түгээх зорилгоор “Түүх, соёлын дурсгалт газруудаа хайрлан хамгаалцгаая” сэдэвт цуврал арга хэмжээг 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулав.

Арга хэмжээний үеэр Шинжлэх ухааны академийн археологийн хүрээлэнтэй хамтран 5 хөшөө баримал, 5 сүм хийд, 3 археологийн дурсгалын талаар танилцуулга бэлтгэж, Монголын Аялал жуулчлалын холбоо, Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдийн холбоо, Улаанбаатар музей, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоо, Аялал жуулчлалын маркетингийн холбоо зэрэг байгууллагуудтай хамтран видео нэвтрүүлэг бэлтгэн хэвлэл мэдээлэл, цахим сайтууд болон <https://www.youtube.com/> сайтад байршуулж, хөшөө дурсгалыг сэргээн засварлах, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг хийж гүйцэтгэв.





**3. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийгэм, соёлын нөлөөллийг зохистой түвшинд хүргэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд:**

- **“Дээлтэй монгол наадам” арга хэмжээг сурталчилж ажиллав.**  
Монголчуудын уламжлалт өв соёл, үндэсний хувцасны язгуур хэв шинж, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, дэлхий дахинд Монгол үндэстэн гэдгээ түгээн таниулах зорилгоор 2006 оноос эхлэн

Монгол костюмс ХХК, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран Дээлтэй Монгол наадмыг жил бүрийн 7 дугаар сарын 10-ны өдөр жанжин зохион байгуулсаар ирсэн. Дэлхий нийтэд тархаж байгаа шинэ коронавирусийн /КОВИД-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Аялал жуулчлалын зарим эвент арга хэмжээ зохион байгуулахыг цуцлах тухай” А/89 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн дагуу “Дээлтэй монгол наадам” арга хэмжээ цуцлагдсан ч Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 369 дүгээр тогтоолоор жил бүрийн 7 дугаар сарын 09-ний өдрийг “Үндэсний хувцасны өдөр” болгон баталсантай холбогдуулан Монголын үндэсний хувцас, Дээлтэй Монгол наадмын тухай видео, нэвтрүүлэг, зурагт хуудас бэлтгэн [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) сайтад байршуулан хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр сурталчилж, 15.500 хүн үзэж сонирхов.



➤ **“Хийморь морьт харвааны наадам” арга хэмжээг зохион байгуулав.**

Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, үндэсний ёс зан заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, нийслэлийн иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1096 дугаар захирамжийн дагуу “Хийморь” морьт харвааны наадмыг 2020 оны 09 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолборт 2 дахь жилдээ зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр “Хийморь” морьт харвааны тэмцээн зохион байгуулж, Хан Монгол, Баатуд, Дэлт Сум, Намнаа зэрэг 6 клубийн 33 тамирчин Рэйд буюу Ази харваа, Скермиш буюу Түрэг харваа, Тавэр буюу Хүннү харваа гэсэн 3 төрлөөр өрсөлдөж, нийлбэр дүнгээр шалгарсан 9 шилдэг тамирчин 2020 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Олон Улсын Морьт харвааны холбооноос зохион байгуулж буй (ИНАА) Гран При онлайн тэмцээнд оролцов. Наадам зохион байгуулах тухай 51 секундийн видео шторк бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, олон нийтийн сүлжээгээр 6168 хүнд мэдээлэл хүргэж, гадаад, дотоодын 350 гаруй иргэн үзэж сонирхсон ба арга хэмжээний шууд дамжуулалтыг 5209 хүн цахимаар үзсэн байна.





➤ **“Хуралдай наадам-Шонхорын баяр” арга хэмжээг зохион байгуулав.**

Аялал жуулчлалын хугацааг уртасгах, шинэ бүтээгдэхүүн бий болгох, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, биет бус соёлын өвийг сэргээн үндэсний ёс зан заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, шонхор шувууны талаар олон нийтэд сурталчлан таниулах, нийслэлийн иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Хуралдай наадам-Шонхорын баяр”-ыг Байгаль орчин, Аялал жуулчлалын яамтай хамтран 2020 оны 10 дугаар сарын 03-ны өдөр “Чингис хааны хүрээ” цогцолборт 2 дахь жилдээ зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр шонхор шувуу, тайга ноход, морьт харваачдын парад, морьт харвааны бага ав намнаа үзүүлбэр, Тайга нохой-Талын гөрөөчин үзүүлбэр, шилдэг идлэг шонхор шувуу-өв тээгч тэмцээн, шонхор шувууны холын зайн тэмцээн, их бүрэн сээр шалгая тэмцээн, уралдааныг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үндэсний урлагийн их театрын уран бүтээлчдийн урлагийн тоглолтоос үзүүлэв. “Хуралдай наадам-Шонхорын баяр” зохион байгуулах тухай видео шторк бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, 9887 хүнд олон нийтийн сүлжээгээр сурталчилж, 450 гаруй иргэн үзэж, арга хэмжээний шууд дамжуулалтыг 5031 хүн цахимаар үзэж сонирхсон байна.







➤ **“Солонгос улсын соёлын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулав.**

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жил ойг тохиолдуулан Солонгос улсын соёлын өдрүүдийн хүрээнд БНСУ-ын Элчин сайдын яамтай хамтран “Миний мэдэх Солонгос орон”, “Миний очихыг хүсдэг Солонгос орон” сэдэвт гар урлал, уран зургийн уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчдын дунд 4 төрлөөр, “K-Pop Festival in Mongolia-2020” фестивалийг бүжиг болон дуу гэсэн 2 төрлөөр 12-оос дээш насны хүүхэд залуучуудын дунд онлайн хэлбэрээр 2020 оны 10 дугаар сарын 10-наас 11 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж байна.

Уралдааны мэдээ, мэдээллийг 6000 гаруй хүнд цахимаар хүргэж, одоогийн байдлаар нийт 1245 иргэн материалаа ирүүлсэн байна.

**“МИНИЙ МЭДЭХ СОЛОНГОС ОРОН”**

МОНГОЛ УЛС, СОЛОНГОС УЛСЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 30 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ГАР УРЛАЛ, УРАН ЗУРГИЙН УРАЛДААН

**Бүтээлийн сэдэв:**  
 “Миний мэдэх Солонгос орон”  
 “Миний очихыг хүсдэг Солонгос орон”

**Бүтээлд тавигдах шаардлага**

- Уран зураг /төрөл бүрийн будгаар/ А3 хэмжээтэй
- Гар урлал хэмжээ чөлөөт
- Бүтээлүүдийн ар талд бүтээлийн нэр, оролцогчийн овог нэр, нас, хүйс, улс орон, харьяа дүүрэг, сургууль анги, холбоо барих утасны дугаарыг тодорхой гаргацтай бичсэн байх. /Өмнө нь оролцсон бүтээлээ дахин оролцуулахгүй/

**Хамрах хүрээ:** Монгол Улсын Ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчид

**Бүтээл хүлээн авах хугацаа:** 2020.09.14-10.15-ны өдрийн 16:00 цаг хүртэл  
 Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төв  
[https://www.facebook.com/цэхим\\_хаяагаар\\_илгээх\\_болон\\_заавал\\_цаасан\\_суурьтаар\\_төвийн\\_байранд\\_хүлээн\\_авна](https://www.facebook.com/цэхим_хаяагаар_илгээх_болон_заавал_цаасан_суурьтаар_төвийн_байранд_хүлээн_авна)

**Шагнал урамшуулал:**

- Гранпри -1 сурагч, Өргөмжлөл, 500,000 төгрөг
- I байр-8 сурагч, Өргөмжлөл, 300,000 төгрөг
- II байр-8 сурагч, Өргөмжлөл, 200,000 төгрөг
- III байр-8 сурагч, Өргөмжлөл, 150,000 төгрөг

Жич:Шилдэг 300 бүтээлийг шалгаруулж, бэлэ дурсгалын зүйлс гардуулна.

**Шагнал гардуулах ёслол, үзэсгэлэнгийн нээлт:**  
 2020.10.28-ны өдөр Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн “Орд” арт галерейд болно.

Холбоо барих утас: 11-321052, 88444845, 99650660, 89078094

МОНГОЛ УЛС, БНСУ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 30 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД, СОЛОНГОС УЛСЫН СОЁЛЫН ӨДРҮҮДИЙГ ТОХИОЛДУУЛАН “2020 K - POP FESTIVAL IN MONGOLIA” ФЕСТИВАЛИЙГ ОНЛАЙН ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ ГЭЖ БАЙНА.

**2020 K-POP FESTIVAL IN MONGOLIA**

БНСУ-ЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ, UBS ТЕЛЕВИЗ, НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЖ БҮЙ 2020 K - POP FESTIVAL IN MONGOLIA НЬ “БҮЖИГ” БОЛОН “ДУУ” ГЭСЭН ХОЁР ТӨРЛӨӨР ЯВАГДАНА.

ФЕСТИВАЛЬД 12-ООС ДЭЭШ НАСНЫ ХҮҮХЭД ЗАЛУУС ОРОЛЦОХ БӨГӨӨД 3-5 МИНУТЫН БИЧЛЭГИЙГ 9 САРЫН 21 – 10 САРЫН 16 ХҮРТЭЛ “2020 K-POP FESTIVAL IN MONGOLIA” ЦАХИМ ХАЯГААР ИЛГЭГЭЭРЭЙ.

**ШАГНАЛЫН САН:**

- ГРАНПРИ 1 Сая ТӨГРӨГ;
- НЭГДҮГЭЭР БАЙР 700.000 ТӨГРӨГ /ХОЁР ТӨРӨЛД ТУС БҮР/
- ХОЁРДУГААР БАЙР 500.000 ТӨГРӨГ /ХОЁР ТӨРӨЛД ТУС БҮР/
- ГУРАВДУГААР БАЙР 300.000 ТӨГРӨГ /ХОЁР ТӨРӨЛД ТУС БҮР/

**f** “2020 K-POP FESTIVAL IN MONGOLIA” **99279881**



**4. Аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх чиглэлээр бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах чиглэлээр:**

➤ “Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төсөл боловсруулж, аялал жуулчлалын салбарын ажилтнуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналуудыг тусгав.

“Улаанбаатар хотын аялал жуулчлалыг 2017-2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн төслийг 2017 оны 06 сарын 15-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Нийслэлийн Засаг даргын “Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх тухай” 01/2936 тоот албан бичгээр НИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барив.

➤ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн төсөл, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн төсөлд санал өгсөн.

➤ Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тусгах саналыг боловсруулж, 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 2/250 тоот албан бичгээр НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.

**5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, УБ хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах, үйл ажиллагаанд мэргэжлийн холбоодын зөвлөмж, санал, дүгнэлтийг тусгах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:**

➤ Аяллын хөтөч тайлбарлагчийн баримтлах зарчим, тавигдах шаардлага, үйлчилгээ үзүүлэх явцад мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, үүрэг хариуцлагыг тогтоож өгөх зорилгоор “Хөтөч, тайлбарлагчийн ёс зүйн дүрэм”-ийн төсөл боловсруулж, Монголын Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо, Монголын Аялал жуулчлалын холбоо, Аялал жуулчлалын ур чадварын төв, Улаанбаатар аялал жуулчлалын холбоо, Гайд төв, Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв, “Пакс номадика” ХХК-иас санал авч тусгав.


➤ Хөтөч, тайлбарлагч нарт зориулсан гарын авлагын төслийг Монголын Хөтөч тайлбарлагчдын холбооны зөвлөх багш нартай хамтран бэлтгэж, Монголын Аялал жуулчлалын холбоо, Аялал жуулчлалын ур чадварын төв, Улаанбаатар аялал жуулчлалын холбоо, Гайд төв, Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв, “Пакс номадика” ХХК зэрэг мэргэжлийн байгууллагуудын саналыг тусгав.

**6. Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах ажлыг хариуцан зохион байгуулах, энэ чиглэлээр маркетингийн стратеги, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

➤ Дэлхий нийтэд тархаж байгаа шинэ коронавирусийн /КОВИД-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Аялал жуулчлалын зарим эвент арга хэмжээ зохион байгуулахыг цуцлах тухай” А/89 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн дагуу ХБНГУ-ын Берлин хотод зохион байгуулагддаг “Ай-Ти-Би Берлин”, ОХУ-ын Эрхүү хотод зохион байгуулагддаг “Байкалтур”, БНСУ-ын Сөүл хотод зохион байгуулагддаг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүд цуцлагдсан.

➤ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) цахим хуудсыг шинэчлэн [www.visitulaanbaatar.mn](http://www.visitulaanbaatar.mn) цахим хуудастай холбох ажлын хүрээнд Нийслэлийн Мэдээлэл технологийн газартай хамтран [www.visitulaanbaatar.mn](http://www.visitulaanbaatar.mn) цахим хуудасны агуулгыг шинэ портал сайт болох [www.Ulaanbaatar.mn](http://www.Ulaanbaatar.mn) сайтад шинэчлэн оруулах ажлыг “ASTVISION” ХХК-аар гүйцэтгүүлж байна. Цахим хуудаст Улаанбаатар хотын соёлын

өвийг хадгалсан түүхэн дурсгалт газруудын талаарх танилцуулга, гадаадын жуулчдын аюулгүй байдлыг хангах, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх цэс үүсгэн өргөжүүлэв. Мөн [www.visitulaanbaatar.mn](http://www.visitulaanbaatar.mn) сайтад Монгол орны тухай болон цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, гадаад болон дотоодын жуулчдад хүргэх шаардлагатай бүхий л мэдээллийг англи хэл дээр бэлтгэж байршуулах үүднээс төрөлжсөн мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.




➤ Улаанбаатар хотыг гадаад орнуудад сурталчлан таниулах зорилгоор олон улсын хотуудын видео танилцуулгыг судлан Улаанбаатар хотын богино хэмжээний видео шторкийн агуулга бэлтгэн мэргэжлийн байгууллагуудын төлөөллүүдтэй уулзаж саналыг тусган, “IT Agency” ХХК-иар видео шторкийн эх бэлтгүүлж Нийслэлийн Засаг даргын зөвлөх М.Мэнд-Очирт танилцууллаа.



ULAAANBAATAR

**7. Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон ТББ-тай хамтран ажиллах ажлын хүрээнд:**

- НЦУГ-тай байгуулсан 2017-2020 онд хамтран ажиллах Санамж бичгийн дагуу гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, жуулчдад Монголын түүх соёл, нийслэл хотоо сурталчлах зорилгоор Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны Холбоотой хамтран “Оюутан цагдаа-2020” арга хэмжээг 6,7,8-р сард их, дээд сургуулийн 40 оюутныг хамруулахаар төлөвлөсөн боловч Дэлхий нийтэд тархаж байгаа шинэ коронавирусийн /КОВИД-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Аялал жуулчлалын зарим эвент арга хэмжээ зохион байгуулахыг цуцлах тухай” А/89 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн дагуу цуцлагдсан.
- Монголын Хөтөч тайлбарлагчдын холбооны зөвлөх багш нартай хамтран “Хөтөч, тайлбарлагч нарт зориулсан гарын авлаг”-ын төслийг бэлтгэж, Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо, Аялал жуулчлалын ур чадварын төв, Улаанбаатар аялал жуулчлалын холбоо, Гайд төв, Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв, “Пакс номадика” ХХК-иас гарын авлагын төсөлд санал авч НЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээр хянуулан 400 ширхгийг хэвлүүлж, аялал жуулчлалын компаниудын хөтөч тайлбарлагчдад олгов.



- Аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч нарт Улаанбаатар хотыг эерэгээр, зөв тайлбарлах ур чадварыг олгох, гадаад, дотоодын жуулчны аюулгүй байдлыг хангах, анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх, хууль эрх зүйн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоотой хамтран 2020 оны 06-р сарын 15, 16-ны өдөр “Хөтөч, тайлбарлагчдын ур чадвар, хууль эрх зүйн мэдлэг олгох, анхан шатны тусламжийг үзүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж аялал жуулчлалын компаниудын нийт 60 мэргэжлийн хөтөч, тайлбарлагч хамрагдлаа.
- Гадаад, дотоодын жуулчдын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор Нийслэлийн Авто замын хөгжлийн газартай хамтран Гандантэгчилэн хийд, Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн, Д.Сүхбаатарын талбай зэрэг нийтийн эзэмшлийн газарт жуулчин тээврийн үйлчилгээний автобусны зогсоолыг байгуулж, түр зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ байршуулав.





➤ Горхи тэрэлжийн байгалийн цогцолбор газарт аялал жуулчлалын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Налайх дүүргийн ЗДТГ, ГТБЦГХЗ-тай уулзалт хийж, Налайх дүүргийн Засаг даргын 2020 оны А/84 дүгээр захирамжаар Горхи тэрэлжийн байгалийн цогцолбор газарт аялал жуулчлалын үйл ажиллагаа, тохижилт үйлчилгээг сайжруулах, хөрсний бохирдлыг бууруулах, нийгмийн хариуцлагыг өндөрсгөх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, газар зохион байгуулалтад хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэгт Налайх дүүргийн ЗДТГ, НАЖГ, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцож, нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Ажлын хэсэг 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Налайх дүүргийн ЗДТГ-ын иргэний танхимд хуралдаж, Горхи тэрэлжийн байгалийн цогцолбор газрын үйл ажиллагаа, өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний талаар ярилцаж, Нийслэлийн Аялал жуулчлалын газраас “Горхи тэрэлжийн байгалийн цогцолбор газарт аялал жуулчлалын үйл ажиллагааг сайжруулах нь” сэдвээр танилцуулга хийв.

**8. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтийг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод сургалтад хамруулж, мэргэшлийг дээшлүүлэх ажлын хүрээнд:**

➤ Салбарын хүний нөөцийг чадваржуулах мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг 2020 оны 01-р сарын 01-ний өдөр батлав. Уг төлөвлөгөөнд нийт 6 төрлийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөснөөс 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 14 төрлийн сургалтыг зохион байгуулж, нийт салбарын чиглэлээр 3280 төрийн болон хувийн хэвшлийн ажилтан, иргэдийг хамруулав.

**9. Улаанбаатар хоттой хамтын ажиллагаатай хотуудтай аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, нийслэл хотын нутаг дэвсгэрт байгаа аялал жуулчлалын нөөцийг сурталчлах, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:**

➤ Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1254 дүгээр захирамжаар нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаагаар ахлуулсан Улаанбаатар хотын соёлын өв бүхий барилга байгууламж, түүний оршин байгаа газрыг тоолж бүртгэлжүүлэх, хамгаалалтын бүс тогтоох, түүнийг дагасан аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг Дулма лин болон Дамбадаржаалин хийдийн орчныг судалж, тохижилтын ажил хийх санал боловсруулж, Дулма лин хийдийн орчны газрыг чөлөөлөх саналыг Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, тохижилтын ажилд хамтран ажиллах талаар саналыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд албан

бичгээр тус тус хүргүүлсэн. Мөн Дулма лин, Дамбадаржаалин хийд болон Жанжин Д.Сүхбаатарын төрсөн гэрийн буйр, Гүнжийн нүдэн нуур, Улаанбаатар хотын анхны тоосгоны үйлдвэртэй танилцаж холбогдох саналыг Нийслэлийн Соёл урлагийн газарт хүргүүлсэн.




**10. Аялал жуулчлалын байгууллагуудын дунд аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөл бүрийн сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:**

➤ Монголын Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “Хөтөч тайлбарлагчдын ур чадвар олгох” сургалтыг 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 45 хоног хугацаанд, Улсын онцгой комиссоос гаргасан зөвлөмжийн дагуу зохион байгуулж, 10 хөтөч тайлбарлагчдад олон улсын стандартад нийцсэн мэргэжлийн хөтөч, тайлбарлагчийн “Гэрчилгээ” олгов.



➤ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэстэй хоёр дахь жилдээ хамтран хөтөч, тайлбарлагч нарт зориулсан хууль эрх зүйн мэдлэг олгох, жуулчны аюулгүй байдлыг хангах сургалтыг 2020 оны 06 дугаар сарын 15-22-ны өдрүүдэд зохион байгуулж аялал жуулчлалын компаниудын 60 хөтөч тайлбарлагчдад “Гэрчилгээ” олгов.





➤ Нийслэлийн Аялал жуулчлалын газраас санаачилсан “Хөггүй аялал гоё” аяны хүрээнд Цагдаагийн ерөнхий газартай хамтран экологийн цагдаа нарт зориулсан “Ул мөргүй аялал” сэдэвт сургалтыг 2020 оны 07-р сарын 02-ны өдөр зохион байгуулж, экологийн цагдаа нарыг ахлан ажилладаг 10 цагдааг хамруулаа. Сургалтыг “Пак номадика” ХХК-ийн хөтөч тайлбарлагчид хөтлөн явуулсан бөгөөд байгальд хор хохирол, ул мөр үлдээлгүй аялах, хүлээлгэх хариуцлага хууль эрх зүйн талаар мэдээлэл өглөө. Сургалтад хамрагдсан цагдаа нар сургалтаар олж авсан мэдлэг мэдээллээ экологийн цагдаа нарт дамжуулан түгээх юм.





➤ БОАЖЯ-наас 21 аймаг, нийслэлийн бүсэд зохион байгуулсан “Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт”-ын хүрээнд жуулчидтай харилцдаг төрийн байгууллагуудын ажилтнуудын дунд харилцаа, хандлага, ёс зүйн сургалтыг 09-р сарын 25, 10-р сарын 02, 09-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад Буянт-Ухаа дахь хилийн цэргийн 0218 дугаар ангийн шалган нэвтрүүлэх алба, Гадаадын иргэн харьяатын газар, Буянт-Ухаа дахь Гаалийн газар болон Мэргэжлийн хяналтын газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Нисэх буудлуудын удирдах газар, Авто тээврийн үндэсний төв, Улаанбаатар төмөр замын олон улсын галт тэрэгний нийт 500 орчим ажилтан хамрагдлаа.



➤ БОАЖЯ-наас хоёр дахь жилдээ зохион байгуулсан “Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалт”-ын нийслэлийн бүсийн сургалтыг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төв, Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төвтэй хамтран 2020 оны 09-р сарын 18-наас 10 дугаар сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулав.

Олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан сургалтын нэгдсэн хөтөлбөрийн хүрээнд 10 мэргэжил тус бүрээр, үнэ төлбөргүй явагдсан тус сургалтад зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз, гэр буудал, ресторан, зоогийн газрын үйлчилгээний ажилтнууд, зочлох үйлчилгээний салбарт ажиллах сонирхолтой 2700 гаруй иргэд, залуус хамрагдаж Гэрчилгээ авлаа. Сургалтыг Тогооч, Бартендер, Бариста, Зөөгч, Зочин угтагч, Өрөөний үйлчлэгч, Хаалгач, Ачаа зөөгч, Жолооч, Хөтөч тайлбарлагч, Удирдлага, Тогоочийн сургалт зэрэг 10 мэргэжил тус бүрээр зохион байгуулав.

Тогооч





Бартендерийн сургалт



Баристагийн сургалт



Зөөгчийн сургалт



Зочин угтагчийн сургалт



Өрөөний үйлчлэгчийн сургалт





Хаалгач-ачаа зөөгчийн сургалт



Жолоочийн сургалт



Хөтөч тайлбарлагчийн сургалт



Удирдлагын сургалт



➤ Аяллын хөтөч тайлбарлагчийн баримтлах зарчим, тавигдах шаардлага, үйлчилгээ үзүүлэх явцад мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, үүрэг хариуцлагыг тогтоож өгөх зорилгоор тус газрын даргын 2020 оны 06-р сарын 02-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар “Хөтөч, тайлбарлагчийн ёс зүйн дүрэм”-ийг батлуулж, Монголын Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна.



**11. Гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр шуурхай хангаж, УБ хотын талаарх сурталчилгааны материалуудыг тогтмол шинэчлэх арга хэмжээ авч ажиллах талаар:**

- Хэвлэмэл сурталчилгааны тараах материалын захирамжийн төслийг боловсруулан НЗДТГ-ын даргад хүргүүлсэн. Дэлхий нийтэд тархаж байгаа шинэ коронавирусийн КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 5 хэл дээрх “Улаанбаатар” сурталчилгааны сэтгүүл хэвлэхийг түр хугацаагаар хойшлуулсан байгаа.
- Улаанбаатар брэнд бэлэг дурсгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, гадаад улс орны жуулчдын сонирхлыг ихээр татдаг бэлэг дурсгалын бүтээгдэхүүний судалгааг онлайн дэлгүүр болон цахим хаягуудаар судалгаа хийв. Мөн Улаанбаатар хотын жуулчид ихээр үйлчлүүлдэг бэлэг дурсгалын дэлгүүрээс судалгааг цаасаар болон утсаар авсан. Үүнд: Чингэлтэй дүүрэгт байрлах 6-н аж ахуйн нэгж болон бэлэг дурсгалын 5 дэлгүүрийг хамруулав. Үүний үр дүнд жуулчдын зайлшгүй авах магадлалтай 10 ширхэг бэлэг дурсгалын бүтээгдэхүүний жагсаалтыг гаргав.




- “Каритас Чех Репаблик” ТББ-тай хамтран “Хоггүй аялал гоё” аяны хүрээнд 500 ширхэг “Ulaanbaatar” брэнд эко даавуун торыг бэлтгэн гаргаж 250 ширхгийг иргэд олон нийтэд тарааж сурталчлав.



- “Аялал жуулчлалын маркетингийн товчоо”-той хамтран “Улаанбаатар хот орчимд аялахуй”, “Эх орноороо аялахуй” 2000 ширхэг номонд “Ulaanbaatar” брэнд бичиглэлийг хэвлүүлэв.





- Хувиараа бизнес эрхлэгч Баянбилэгтэй хамтран 150 ширхэг модон түлхүүрийн оосрыг “Улаанбаатар” явган аяллын фестивалийн үйл ажиллагаанд оролцсон иргэдэд тараан сурталчлав.



- “Улаанбаатар” брэндийн бэлэг дурсгалын бүтээгдэхүүний судалгааг хийж хамтран ажиллах аж ахуйн нэгжүүдэд санал тавьсан.



- “Улаанбаатар” брэндэд хамтран ажиллах аж ахуйн нэгжүүдэд брэндийн талаар танилцуулга хийв.



**12. Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн үзэсгэлэн, арга хэмжээнд энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ-уудыг хамруулах талаар:**

- Дэлхий нийтэд тархаж байгаа шинэ коронавирусийн /КОВИД-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Аялал жуулчлалын зарим эвент арга хэмжээ зохион байгуулахыг цуцлах тухай” А/89 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн дагуу олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэн арга хэмжээнүүд цуцлагдсан.
- Олон улсын “Койка” байгууллагаас зохион байгуулсан “Хамтран ажиллагч байгууллагуудын цахим хурал”-д оролцож, саналаа илгээв.
- Монгол, Орос, Хятад гурван улсын аялал жуулчлалын сайд нарын тавдугаар хуралдаан 2020 оны 10 дугаар сарын 20-ны цахимаар зохион байгуулагдав. Энэ удаагийн хурлыг ОХУ-ын Холбооны Аялал жуулчлалын агентлагаас зохион байгуулсан бөгөөд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас үүдэн хамгийн их хохирол амссан аялал жуулчлалын салбарыг эргэн сэргээх, гурван улсын аялал жуулчлалын маршрутыг бий болгох, салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг чиглэлээр хэлэцсэн юм. Цахим хуралд гурван улсын аялал жуулчлалын салбарын удирдлагууд, мэргэжлийн холбоодын зөвлөл, төр болон хувийн хэвшлийн аялал жуулчлалын төлөөллүүд оролцлоо.



**13. Жуулчдад зориулсан мэдээлэл сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар:**

- “Улаанбаатар хотын жуулчны мэдээллийн төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/283 дугаар захирамжийн дагуу батлагдсан



төсвийн санхүүжилтийг улирал бүрээр хуваарилан авч ажиллаж байна. Төв салбар болох "Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв", Төв шуудан дахь "Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв"-өөр 2020 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 52 гадаадын жуулчин үйлчлүүлсэн ба лавлах утсаар 620 дуудлагад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллав.

**14. Жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, тэдгээрийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах талаар:**

➤ Төв салбар болох "Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв", Төв шуудан дахь "Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төв"-д 2020 оны 3 дугаар улирлын байдлаар жуулчидтай холбоотой санал гомдол ирээгүй болно.

**15. Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудыг бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж хөтлөх талаар:**

➤ Жил бүр мэдээлэл, сурталчилгааны төвүүдийн мэдээллийн нэгдсэн санд нийслэл, орон нутгийн аялал жуулчлал, соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд /тур оператор компаниуд, байршуулах хэрэгслүүд, музей галерей, урлагийн байгууллага, үзвэр үйлчилгээний газар, номын дэлгүүр/-ын болон түүх соёлын дурсгалт газрууд гэх мэт 2000 гаруй байгууллагын мэдээллээр мэдээллийн сан үүсгэж, үзвэр, худалдаа, үйлчилгээний хуваарь, аялал жуулчлалын чиглэлээр болон бусад эвент арга хэмжээний мэдээ, мэдээлэл зэрэг 10.000 гаруй мэдээллийг бэлтгэж, шинэчлэн ажиллаж байна.

**16. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх талаар:**

Эрхэлсэн ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гадаад харилцааны яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтсүүд, Захирагчийн ажлын алба, нийслэлийн 9 дүүрэг, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагууд, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа их дээд сургуулиуд, төрийн бус байгууллагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээ мэдээллийг цаг тухайд түргэн шуурхай өгч ажиллаж байна.

**17. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах талаар:**


➤ Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "Аз жаргалтай хот" хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотод аялж, жуулчилж буй гадаадын иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн Цагдаагийн газар, Нийслэлийн Онцгой байдлын газартай, Улаанбаатар хотын аялал жуулчлалын үйл ажиллагааг сурталчлах, мэдээллийг олон нийтэд түргэн шуурхай хүргэх зорилгоор МҮОНРТ, ИНЕГ, Нийслэлийн сэтгүүлчдийн нэгдсэн холбоо, үйлчилгээний чанар стандарт мөрдүүлэх, үйлчилгээний ажилтнуудыг мэргэшүүлэх, мэдлэг ур чадварыг сайжруулах сургалт зохион байгуулахаар Монголын Зочид буудлуудын холбоо, Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдийн холбоо, Монголын Аялал жуулчлалын холбоо, эвент арга хэмжээг хамтран зохион байгуулахаар Улаанбаатарын Аялал жуулчлалын холбоо зэрэг байгууллагуудтай 2016-2020 онд хамтран ажиллах Санамж бичиг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

➤ 2020 онд нийслэл Улаанбаатар хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх, салбарын хүний нөөцийг

чадавхжуулах, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, сургах, аялал жуулчлалын салбарын мэдээ, мэдээллийг харилцан солилцох, төрөл бүрийн судалгаа, шинжилгээ хийх, олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийг хамтран хэрэгжүүлэх, “Хөтөч тайлбарлагчийн ёс зүйн дүрэм”-ийг анх удаа мөрдүүлж ажиллахаар Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Аялал жуулчлалын холбоо, Мэргэжлийн хөтөч тайлбарлагчийн холбоо хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулав.



➤ “Соёлын солилцоо хөгжлийн төв” ТББ-тай Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичгийг 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан. Санамж бичгийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх олон талт үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийг зохион байгуулах, аялал жуулчлалын гарааны бизнесийг дэмжих, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нэмэгдүүлэх, жуулчдын зорин очих газрыг бий болгох, олон нийтийн аялал жуулчлалын боловсролыг дээшлүүлэхэд нөлөөлөх, тэдгээрт чиглэсэн арга хэмжээнүүдийг хамтран зохион байгуулна.



## 18. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийн хүрээнд:

### А. Зохион байгуулалтын чиглэлээр:

- Авилгын эсрэг хууль тогтоомж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор [tourism.ub.gov.mn](http://tourism.ub.gov.mn) цахим хуудас, шилэн данс цэсийн мэдээллийг цаг тухай бүр шинэчлэн ажиллав.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас тус байгууллагын 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын талаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлын хурлаас гаргасан зөвлөмжийн дагуу 15 заалттай ажлын төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд НЗДТГ, Хотын стандарт орчны аюулгүй байдал, хяналт зохицуулалтын газраас зохион байгуулсан сургалтад тус газрын 3 хэлтсийн дарга, 2 мэргэжилтэн хамрагдлаа.
- “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-д жуулчдад зориулсан эвент, арга хэмжээ болон үйл ажиллагааг зохион байгуулах тухай саналыг боловсруулж газрын даргад танилцуулан, нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт хүргүүлэв.

- Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлах түүх, соёлын үл хөдлөх дурсгалаас түүхэн үеийг төлөөлөхүйц, шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой газруудын арчлалт хамгаалалтыг сайжруулах, орчныг тохижуулах, түүнийг дагасан аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар судалж, санал боловсруулах зорилгоор Гачууртын амны хадны зураг, Их Тэнгэрийн амны хадны зураг, Туулын хар түнийн ордны туурь, Ар гүнтийн дөрвөлжин булшны цогцолбор, Бэлхийн амны хүннүгийн язгууртны оршуулгын цогцолбор зэрэг 5 дурсгалт газраар очиж танилцан, санал боловсруулан газрын даргад танилцуулсан.
- IT Agency” ХХК-тай хамтран “Нэг мод, Нэг жуулчин” төслийн агуулга, зорилт, зорилго, хүрэх үр дүнгийн төсөл гаргаж танилцуулсан.
- Нийслэлийн Засаг даргын Инноваци технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч М.Халиунбатаар ахлуулсан “КОВИД-19” цар тахлын үед эдийн засгийн эрсдэлийг бууруулах, хөл хорионы хязгаарлалтыг үе шаттайгаар сулруулах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг”-т зочлох үйлчилгээний байгууллага /амралтын газар, жуулчны бааз, гэр буудал, зочид буудал, дэн буудал/-уудын дагаж мөрдөх зааварчилгааны санал боловсруулж танилцуулсан.
- Улаанбаатар брэндийн бэлгэ тэмдгийг үр дүнтэй ашиглах ажлыг эрчимжүүлэхээр удирдамж, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг газрын даргын 2020 оны А/25 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлал, зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад мөрдөгдөж байгаа MNS4588:2008, MNS5738:2007, MNS6043:2009 стандарт болон Нийслэлийн Засаг даргын А/456 дугаар захирамжаар баталсан стандартуудыг мөрдүүлэх арга зүйн баримт бичиг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгүүдийг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Байгууллагын 2020 оны эхний хагас жилийн байдлаар edoc программаар нийт 642 албан бичиг бүртгэгдсэн ба хариутай албан бичиг 360, хариугүй 282 байна. Байгууллагаас гадны 215 байгууллагад нийт 306 албан бичиг явуулсан ба А тушаал 48, Б тушаал 20-г батлав. Ирсэн явсан бичгийн бүртгэл хөтөлж, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор албан бичгийн шийдвэрлэлтэд сар тутам хяналт тавьж, ажиллаж байна.
- 2019 оны нийт 219 баримтыг байгууллагын архивт хүлээн авч архивлав. Үүнд: Байнга хадгалах 69ш боть, түр хадгалах 116ш боть, 70 жил хадгалах 3ш боть, цахимаар дүрс бичлэгийн хуурцаг/CD/ 16ш, цомог 14ш, гэрэл зураг 1 боть /1588ш гэрэл зураг/-ийг байгууллагын архивт хүлээн авлаа.
- Албан ажлын хэрэгцээнд дахин ашиглах боломжгүй болсон, ашиглалтын хугацаа дууссан 33 нэр төрлийн 6.989.779 төгрөгийн үнэтэй 42 ширхэг эд хөрөнгийг газрын даргын “Хөрөнгө актлах тухай” 2020 оны А/44 дүгээр тушаалаар бүртгэлээс хасав.
- Газрын үндсэн хөрөнгө, материалын тооллого хийх комиссыг газрын даргын 2020 оны А/41 дүгээр тушаалаар баталж, хэрэгжилийг хангаж ажиллав.
- Ажлын байрны ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор жуулчдад мэдээлэл өгөх “Мэдээлэл, сурталчилгааны төв”-ийн үүдний шат эвдэрсэн байдалтай гадны болон дотоодын иргэд орж гарахад гэмтэл учруулах магадлалтай байсан тул өнгө үзэмжийг засаж сайжруулан эвдрэлийг засав.



Шатны өмнөх байдал



Шатыг засуулсан байдал

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас санаачилсан “Өгөөмөр нийслэлчүүд” аянд нэгдэж 11 нэр төрлийн 112 ширхэг эд зүйлс хүлээлгэн өглөө.





**Б. Цаг үеийн ажлын шаардлагаар дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаар:**

➤ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016 дугаар захирамж, 2019 оны “Түүхий нүүрсний тээвэрлэлт хэрэглээнд хяналт тавих тухай” А/1118 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтны хуваарь”, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нийслэлийн онцгой комиссын даргын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтны хуваарь”, “Нийслэл дүүргийн Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд 24 цагаар хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын удирдамж”- ийн дагуу тус газар Чингэлтэй дүүргийн 17,18 дугаар хороодод байрлах 4122 өрхөд “Таван толгой” ХХК-ний сайжруулсан түлшний тээвэрлэлт, нөөцлөлт, борлуулалтын 8 цэгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллав.



Мөн Чингэлтэй дүүргийн 17, 18 дугаар хороодод хуваарилагдсан угаар мэдрэгч төхөөрөмжүүдийг хүлээлцэх, тарааж суурилуулах ажилд хяналт тавьж ажиллав.



➤ Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах, Нийслэлийн Онцгой Комиссын 2020 оны 02 дугаар сарын 15 ний өдрийн 4 дүгээр өргөтгөсөн хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх эргүүлийн үүрэг гүйцэтгэх ажлын хүрээнд НАЖГ-ын хариуцсан СХД-ийн 19-р хорооны нутаг дэвсгэрт 02-р сарын 15-наас 05 дугаар сарын 29-нийг хүртэл өдөр бүр хуваарийн дагуу хэсгийн ахлагч, олон нийтийн цагдаагийн хамт эргүүлийн үүргийг гүйцэтгэж амны хаалтгүй иргэнд шаардлага тавьж ажиллалаа. Мөн Хан-Уул дүүрэг дэх Өлзийтийн пост дээр 1 ажилтан 24/48 цагийн жижүүрийн үүргийг гүйцэтгэн автомашинаар орох гарах зорчигчдоос асуулга авч, амны хаалт зүүхийг зөвлөж ажиллав.



➤ Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах, Нийслэлийн Онцгой Комиссын 2020 оны 02 дугаар сарын 15 ний өдрийн 4 дүгээр өргөтгөсөн хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн 01/64 дүгээр тоот зөвлөмжийн дагуу 2020 оны 2 дугаар сарын 18-19 ний өдрүүдэд Улаанбаатар хотын 7 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлуудад шинэ Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулан 254 аж ахуйн нэгжийг хамруулж гадаад, дотоод орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт



зэрэгт хяналт тавьж, газрын даргаас гаргасан зөвлөмжийн хамт урьдчилан сэргийлэх зурагт материалаар ханган аж ахуйн нэгжүүдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



➤ Нийслэлийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Өнжмөл өвсний түймэр гарахаас урьдчилан сэргийлэх тухай” А/487, 04 дүгээр сарын 16-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай” А/521 дүгээр захирамж, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 17-ны А/249 дүгээр тушаалаар батлагдсан “Үйлчилгээний зарим байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуй, халдварын сэргийлэлт, хяналтын түр журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилготойгоор Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалангийн 2020 оны 04-р сарын 30-ны өдөр баталсан “Амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлуудад үзлэг, шалгалт зохион байгуулах” удирдамжийн дагуу үзлэг шалгалтыг 2020 оны 05-р сарын 01-08-ний өдрүүдэд зохион байгуулав. Үзлэг шалгалтад 8 дүүргийн 23 зочид буудал, 25 дэн буудал, 129 амралтын газар, жуулчны бааз хамруулж, зөвлөмж мэдээлэл өгсөн ба 8 зочид буудал, 9 дэн буудал, 21 амралтын газар, жуулчны баазуудад 7-14 хоногийн хугацаанд үйл ажиллагаагаа сайжруулах, зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулах тухай “Мэдэгдэх хуудас” өгч ажиллалаа.

Улаанбаатар хотын 7 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах амралтын газар, жуулчны бааз, дэн буудлуудад шинэ Корона вирусийн халдвар нь олон улсын хэмжээнд өргөн хүрээтэй тархаж байгаатай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 26-ний өдрийн А/223 дугаар захирамжаар өгөгдсөн үүргийн дагуу нийт 238 аж ахуйн нэгжтэй утсаар холбогдож захирамжийг танилцуулан заагдсан хугацаанд үйл ажиллагаагаа түр зогсоох тухай зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн 3 төрлийн зурагт мэдэгдэл гарган Нийслэлийн аялал жуулчлалын газрын цахим хуудас, зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүд, явган аяллын групп, аялал жуулчлалын салбарын мэдээллийн цахим хуудаснуудад байршуулан нийт 105 аж ахуйн нэгж, 17300 хүнд хүргэн ажилласан байна.

➤ “Ковид-19” халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс иргэдийг хамгаалах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх, эрүүл ахуйн зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын баталсан “Амны хаалтаа зүүцгээе” аяны удирдамжийн дагуу тус газраас дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Нийслэлийн Аялал жуулчлалын хамт олон “Амны хаалт бидний аюулгүйн баталгаа” уриа бүхий амны хаалтыг зүүж хэвших дадлыг уриалсан социал челленж зарлан олон нийтийн сүлжээнд тавьж тус аяныг сурталчилж ажиллав.





2. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчид иргэдтэй амны хаалттай ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, санамж, зааварчилгааг ажлын байрандаа байршуулж ажилласан.



3. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын цахим хуудсанд “Амны хаалт бидний аюулгүйн баталгаа” зурагт санамжийг аялал жуулчлалын салбарын мэдээлэл бүхий 12 фэйсбүүк хуудсанд байршуулан аж ахуй нэгж байгууллага, иргэдэд хүргэн ажилласан.



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

## Амны хаалт бидний аюулгүйн баталгаа



АМНЫ ХААЛТАА ЗҮҮЦГЭЭ !!!

4. “Амны хаалтаа зүүцгээ” уриатай фэйсбүүк хүрээг байгууллагын албан хаагчид профайл зурагтаа тавьж, нийгмийн сүлжээнд давлагаалж олон нийтэд хүргэн ажиллаж байна.



➤ Улсын Онцгой штабаас өгсөн үүрэг даалгаврын дагуу тус газрын дарга, захиргааны хэлтсийн дарга, 2 мэргэжилтний хамтаар ажиллаж тусгаарлах байрны зориулалтаар ашиглах 21 зочид буудлын бэлтгэж, Улсын Онцгой штабт хүлээлгэн өглөө.


**Б/. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР**

- Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу НАЖГ-ын төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх 15 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 86 дугаар тогтоолоор НАЖГ-ын албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл олгосны дагуу тус газрын даргын 2020 оны А/30 дугаар тушаалаар батлав. Албан тушаалын тодорхойлолтыг албан хаагч тус бүрт танилцуулж, гарын үсэг зуруулан хүлээлгэн өгөв.
- Монгол Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоол, 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/452 дугаар захирамжийг тус тус үндэслэн албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдэл хөлсийг шинэчлэн тогтоов.
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ажилтан урьж Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлан, биелэлт гаргах арга зүйн сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулав.
- Албан хаагчдын ажилласан жил, зэрэг дэвийн судалгааг үндэслэн 4 албан хаагчийн зэрэг дэвийн нэмэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/452 дугаар захирамжийн дагуу 3 удирдах албан тушаалтан, 2 гүйцэтгэх албан тушаалтны зэрэг дэвийн нэмэгдлийг олгов.
- Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 /Төрийн албаны хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ/, Газрын дүрмийн 3.1.8 /аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжилтийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод сургалтад хамруулж, мэргэшлийг дээшлүүлэх/ дахь хэсгийг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвтэй хамтран 2020 оны 05 сарын 18-21-ний өдрүүдэд Хууль эрх зүй, Төрийн албан хаагчийн ёс зүй, MS Excel, Судалгааны арга зүй чиглэлээр нийт 4 төрлийн сургалтад 16 албан хаагчыг мэргэшүүлэв.

НЗД-ын 2020 оны А/1076 дугаар захирамжийн хүрээнд НЗДТГ болон НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан “Монгол Улсын урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан нийслэлийн дунд хугацааны бодлогыг боловсруулах нь”, НЗДТГ, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, туршлага, сургамж, зөвлөмж”, Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас зохион байгуулсан “COVID-19” цар тахлын улмаас хямралтай тулгарч буй Жижиг дунд бизнесийн салбар /аялал жуулчлал, зочлох үйлчилгээ/-ынханд зориулсан онлайн сургалт, НЗД-ын 2020 оны А/1076 дугаар захирамжийн хүрээнд НЗДТГ болон НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан “Монгол Улсын урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан нийслэлийн дунд хугацааны бодлогыг боловсруулах нь”, Олон улсын “Койка” байгууллагаас зохион байгуулсан “Хамтран ажиллагч байгууллагуудын цахим хурал”-д оролцож, НЗДТГ, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, туршлага,



сургамж, зөвлөмж” сэдэвт сургалтад тус бүр 1 ажилтан хамрагдав. Нийт 11 төрлийн сургалтад давхардсан тоогоор 26 албан хаагчийг хамруулав.



➤ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвөөс 2020 оны 05 сарын 21, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан “Манлайлал”-ын сургалтад тус газрын дарга С.Батбаатар хамрагдав.

➤ НЗД-ын 2020 оны А/1076 дугаар захирамжийн хүрээнд НЗДТГ болон НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан “Монгол Улсын урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан нийслэлийн дунд хугацааны бодлогыг боловсруулах нь”, НЗДТГ, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, туршлага, сургамж, зөвлөмж”, Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас зохион байгуулсан “COVID-19” цар тахлын улмаас хямралтай тулгарч буй Жижиг дунд бизнесийн салбар /аялал жуулчлал, зочлох үйлчилгээ/-ынханд зориулсан онлайн сургалт, НЗД-ын 2020 оны А/1076 дугаар захирамжийн хүрээнд НЗДТГ болон НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан “Монгол Улсын урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан нийслэлийн дунд хугацааны бодлогыг боловсруулах нь”, Олон улсын “Койка” байгууллагаас зохион байгуулсан “Хамтран ажиллагч байгууллагуудын цахим хурал”-д оролцож, НЗДТГ, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран зохион байгуулсан “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, туршлага, сургамж, зөвлөмж” сэдэвт сургалтад тус бүр 1 ажилтан хамрагдав.

➤ Шинэ Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 0-12 насны хүүхэдтэй эмэгтэй албан хаагчдыг ажлын цагийг 2 сар 1 цагаар багасгаж ажиллуулав.

➤ Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, шинэ төрлийн корона вирус “КОВИД-19”-ийн халдвараас иргэд, олон нийтийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцлагатай жижүүр эргүүлээр идэвхи санаачлага гарган ажилласан албан хаагчдад үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх мөнгөн урамшуулал олгов.

- Газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/23 дугаар тушаалаар “Эцэг, эхийн зөвлөл”-ийг шинээр байгуулж, зөвлөл 2020 онд хийж хэрэгжүүлэх 2 бүлгийн 10 заалт бүхий арга хэмжээний төлөвлөгөө батлуулав. Зөвлөлийн гишүүдэд хүүхэд хамгааллын бодлого шийдвэр, албан хаагчдад хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийг танилцуулав.
- Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан газрын даргын 2020 оны А/35 дугаар тушаалаар албан хаагчдын 33 хүүхдэд 899.250 төгрөгийн бэлэг дурсгалын зүйл олгов.

## **В. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ /КРИ-ЭЭР ҮНЭЛСЭН МЭДЭЭЛЭЛ**

### **1. Жуулчдад зориулан зохион байгуулж буй эвент арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулж дотоод гадаадын иргэд, жуулчдын тоог нэмэгдүүлсэн байдал:**

- Дэлхий нийтэд тархаж байгаа шинэ коронавирусийн /КОВИД-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Аялал жуулчлалын зарим эвент арга хэмжээ зохион байгуулахыг цуцлах тухай” А/89 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн дагуу “Улаанбаатарын өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Талын салхи” арга хэмжээнүүд цуцлагдсан.

### **2. Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах ажлыг оновчтой зохион байгуулж, олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход уг үзэсгэлэнг үзэж сонирхсон хүмүүсийн тооны нэмэгдсэн байдал:**

- Дэлхий нийтэд тархаж байгаа шинэ коронавирусийн /КОВИД-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Аялал жуулчлалын зарим эвент арга хэмжээ зохион байгуулахыг цуцлах тухай” А/89 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн дагуу олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэн арга хэмжээнүүд цуцлагдсан.

### **3. Улаанбаатар хотод ирсэн жуулчдын зорин очих газрыг шинээр бий болгож аялал жуулчлалын эргэлтэд оруулсан байдал:**

- Газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Түүх, соёлын дурсгалт газруудаа хайрлан хамгаалцгаая” сэдэвт цуврал арга хэмжээ зохион байгуулах тухай” А/26 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд Шинжлэх ухааны академийн археологийн хүрээлэнтэй хамтран Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт байрлах түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон археологийн ач холбогдол бүхий Гачууртын амны хадны зураг, Их Тэнгэрийн амны хадны зураг, Туулын хар түнийн ордны туурь, Ар гүнтийн дөрвөлжин булшны цогцолбор, Бэлхийн амны хүннүгийн язгууртны оршуулгын цогцолбор зэрэг 47 газрын судалгааг шинэчлэн тогтоов. Уг газруудад хамгаалалтын бүс тогтоосон эсэх, газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн эсэх, хамгаалалтад авах зэрэг саналаа нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэв.

## **Г. ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ**



➤ Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай барагдуулах, санал хүсэлт ирснээс хойш 7 хоногт багтаан шийдвэрлэх талаар заалтыг нийт ажилтнуудын үр дүнгийн гэрээнд тусгаж, байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг байгууллагын хурлаар нийт ажилтнуудад хэлэлцүүлж, 2020 оны байдлаар нийт 18 өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч түүний 18 өргөдөл, гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 13 хоног 3 цаг 52 минут байна. Энэ хугацаанд тус газар хандаж гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудад хариуг албан бичиг болон утсаар мэдэгдэж 100% барагдуулав.

Өргөдөл, гомдлын төрлөөр нь ангилвал:

Д/д	Ангилал	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл гомдлын хувь
1	Ажлаас чөлөөлөгдөх тухай	2	11,3%
2	Хүүхэд асрах чөлөө хүсэх тухай	1	5,5%
3	Ажилд орох тухай	1	5,5%
4	Зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагааны тухай	14	77,7 %
Нийт өргөдөл, гомдлын дүн		18	100%

#### **Д/. БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААТАЙ**

2020 оны байдлаар тус газраас худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй болно.

#### **Е/. НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ САНД ОРУУЛСАН ТАЙЛАН МЭДЭЭ**

➤ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны Журам батлах тухай 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны Журам батлах тухай А/335 дугаар захирамжийн дагуу байгууллагын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлтийг цаг хугацаанд нь гаргаж даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлын тэмдэглэлийн хамт албан тоотоор НЗДТГ-ын ХШҮХ-т, тайлан мэдээг [monitoring.ub.gov.mn](http://monitoring.ub.gov.mn) сайтад байршуулж ажиллав.

Байгууллагын үйл ажиллагаанд 2020 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөнд нийт 5 зорилт, 15 ажлыг төлөвлөж газрын даргаар батлуулав. 2020 оны байдлаар бодлогын зорилт, тогтоол шийдвэр, нийслэлийн удирдлагаас гаргасан шийдвэр, архив, байгууллагын ил тод байдал, өргөдөл гомдол, хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр нийт 10 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

#### **ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**

##### **НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

/2020 ОНЫ БАЙДЛААР/

2020 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
---	------------------	-----------	------

Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Нийслэлийн аялал жуулчлалын газрын дүрэм, эрхэм зорилго, зорилт, бүтцийг цахим хуудаст шинэчлэн байршуулсан.	100
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Албан хаагчдын харилцах утас цахим хаяг, байгууллагын мөрдөгдөж байгаа дүрэм журмыг цахим хаяг, болон мэдээллийг самбарт тухай бүр шинэчлэн байршуулан ажиллаж байна.	100
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байрлуулан тухай бүр шинэчлэх	НИТХ-ын Тэргүүлэгчдийн 120 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз гэр буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалтыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ил тод байршуулсан.	100
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Хөдөлмөрийн дотоод журам, Ёс зүйн дүрэм болон Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр холбогдох дүрэм журмыг байгууллагын цахим хуудаст байршуулсан.	100
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг байхгүй.	-
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Зочид буудал, дэн буудад, амратын газар, жуулчны баазын стандартын үнэлэх аргачлалыг боловсронгуй болгосон.	100
7	Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн	Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн	-



	бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухай төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх	байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа ажил байхгүй.	
8	Тухай байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудаснаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз, гэр буудлын зөвшөөрөл олгосон тухай газрын даргын тушаалыг тухай бүр байршуулж байна.	70
9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй.	-
Хэсгийн дундаж хувь:			95.7
Хоёр: Хүний нөөцийн ил тод байдал			
1	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах	2 сул орон тооны мэдээлэл, захиалгыг Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэв.	100
2	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны болон үйлчилгээний Ёс зүйн дүрэм” 33 дугаар тогтоолыг байгууллагын цахим хуудаст байрлуулсан.	100
3	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	Цахим хуудаст байршуулав.	100
4	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хянах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг тухай бүр шинэчилж цахим хуудаст байршуулсан.	100
5	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг улирал бүр цахим хуудаст байршуулав.	100

Хэсгийн дундаж хувь:		100
Хэрэгжилтийн дундаж хувь: 97.85		

### ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД МЭДЭЭЛЭЛ

#### А/. Чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр:

➤ Нийслэл хотын зочид буудал, дэн буудлуудын үйлчилгээний чанар, ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах, зочлох үйлчилгээний салбарын эрхлэгч, менежер, ажилтнууд, жуулчидтай шууд харилцдаг төрийн байгууллагын ажилтнуудад зориулж үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдал, харилцааны соёл, хөтөч-тайлбарлагчийн зэрэг сургалтуудыг зохион байгуулах болон тус газраас жуулчдад зориулсан аялал жуулчлал, спорт, соёл урлагийн арга хэмжээг аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын төлөөлөл бүхий хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх үүднээс төрийн болон төрийн бус гадаад, дотоодын 8 байгууллагуудтай хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулж, 21 байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажиллав.

Мөн шинэ төрлийн корона вирус “КОВИД-19”-ийн халдвараас иргэд, олон нийтийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Нийслэлийн Онцгой комиссоос үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

#### Б/. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан ажлын талаарх:

➤ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж, стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгжид үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгон ажиллаж байна. 2020 оны эхний хагас жилийн байдлаар тус газарт дүүрэг, цагдаагийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 3 байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын тушаалаар хүчингүй болгов.

#### В/. Шинээр санаачилсан ажлууд:

##### Нэг. “ХОГГҮЙ АЯЛАЛ ГОЁ АЯН” ЗОХИОН БАЙГУУЛАВ.

➤ Ажилтнуудын дунд “ХАРИУЦЛАГАТАЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ”-ыг иргэдэд ухамсарлуулах зорилготой “Үгэн уриа” уралдааныг 5 дугаар сарын 25-наас 6 дугаар сарын 2-ныг хүртэлх хугацаанд зарлав. Уралдаанд ирүүлсэн 15 үгэн урианаас мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн “ХОГГҮЙ АЯЛАЛ ГОЁ” уриаг сонгон шалгаруулж сурталчилгааны материалын эх бэлтгэн хэвлүүлж, олон нийтийн мэдээллийн цахим сайтууд, Төмөр замын буудал, Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн, Улаанбаатар зочид буудал, Кемпински Хаан палас зочид буудал, Talk talk english сургалтын төв орчимд байрлах тус газрын сурталчилгааны самбарт байршуулав.







- Байгаль түүх соёлоо хайрлан хамгаалах, соёлын өв, түүхэн дурсгалт газруудаар аялах иргэд болон аж ахуйн нэгж байгууллагуудын хариуцлагатай, байгальд ээлтэйгээр үл мөргүй аялах чиглэлээр олон талт үйл ажиллагаа явуулахын сацуу энэхүү үйл ажиллагааны хүрээнд иргэд болон байгууллагуудад хандан байгаль орчноо хайрлан хамгаалах зорилгоор “ХОГГҮЙ АЯЛАЛ ГОЁ” сэдэвт аяныг зохион байгуулж хамтран ажиллах байгууллагуудыг уг үйл ажиллагаанд нэгдэн “ХОГГҮЙ АЯЛАЛ ГОЁ” уриаг сурталчлах, түгээх аяныг дэмжиж хамтран ажиллахыг уриалсан албан бичгийн нийт 23 байгууллагад хүргүүллээ.

➤ “ХОГГҮЙ АЯЛАЛ ГОЁ АЯН” өрнүүлэв.

“ХОГГҮЙ АЯЛАЛ ГОЁ” уриаг сурталчилж, түгээх зорилгоор 2020 оны 08 дугаар сарын 08-25-ны хооронд “Хоггүй аялал гоё” аяныг өрнүүлэв. Аяныг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Улаанбаатар Смарт Карт ХХК, Zero Waste Club, МҮОНТ, Налайх дүүргийн ЗДТГ, дүүргийн Цагдаагийн хэлтэс, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Жэй Си Ай Конгресс олон улсын байгууллага, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны баазууд, Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Өвөрхангай аймгийн Элсэн тасархай, Эрдэнэзуу хийд Архангай аймгийн Авто пост, Хорго, Тэрхийн цагаан нуур орчмын амралтын газрууд зэрэг нийт 70 гаруй дэмжиж хамтарч ажиллав. Каритас чех републик Монгол дахь суурин төлөөлөгчийн газар Эко тор, Эко бал, Эко номын хавчуурга, Машинд дугаар бичигч 4 бүтээгдэхүүнд хамтран ажиллав.



▶ Facebook frame

▶ Доорх холбоосоор нүүр зургандаа хүрээ хийж аяныг дэмжиж оролцсон [shorturl.at/dpKR2](https://shorturl.at/dpKR2) хийж сурталчлав.



Аяны хүрээнд тус газрын албан хаагчид, Зеро вест клубынхэнтэй хамтран хотоос гарах зүүн чиглэлийн зам дагуу “Сансар” худалдааны төвийн талбайд, Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын албан хаагчидтай хамтран хойд чиглэлд Зунжин худалдааны төв, зүүн чиглэлд Жигжидийн уулзвар Амгалан дахь Оргил худалдааны төв, Сансар үйлчилгээний төв, урд чиглэлд Яармаг дахь Сансар үйлчилгээний төв, баруун чиглэлд 22-н товчоо, хотын төвд Петровисийн 16, 29-р шатахуун түгээх станцууд, Энхтайваны гүүр нарны зам дагуу аянг өрнүүлж, жолоочдод хогийн уут тарааж, авто машинд стикер нааж, хог хаягдлаа ил задгай хаяхгүй байх, хогоо хогийн уутанд хийж зориулалтын цэгт хаяхыг зөвлөж, хоггүй аяллыг уриалан ажиллалаа.



Арга хэмжээний үеэр нийт зурагт хуудас 250, автомашины стикер 3170 ширхэг, хогийн уут 3250 ширхэгийг тарааж ажиллалаа. “ХОГГУЙ АЯЛАЛ ГОЁ” аянг Иргэдийн аялал жуулчлалын боловсролыг дээшлүүлэх аян”-аар үргэлжлүүлэв.

**Хоёр. “ИРГЭДИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АЯН”  
ЗОХИОН БАЙГУУЛАВ.**

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, аялал жуулчлалын байгууллагууд, амралтын газруудтай хамтран ажиллаж, тэдгээрийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах, үндэсний өв соёл, ёс заншил уламжлалыг сэргээх, танин мэдүүлэх, иргэдийг батлагдсан маршрутын дагуу түүх, соёлын өвтэй танилцаж, байгальд ээлтэй, хоггүй, эрсдэлгүй, хариуцлагатай аялах аяллын боловсролыг дээшлүүлэх, цахим аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “ИРГЭДИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОЛОВСРОЛЫГ



“ДЭЭШЛҮҮЛЭХ АЯН”-г соён гэгээрүүлэх, сургах чиглэлээр 2020 оны 08 дугаар сарын 08-25 хүртэл хугацаанд зохион байгууллаа.



“Иргэдийн аялал жуулчлалын боловсролыг дээшлүүх” аяны хүрээнд “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ-т “Гэр мэдээллийн төв”-ийг байгуулж, хүүхэд, залууст нүүдлийн соёлын тухай танилцуулан мэдлэг олгож ажиллав.



Хөөмий, Уртын дуу, Уран Монгол бичиг, асуулт хариултын тэмцээн, Амур брэнд үндэсний дээл хувцасаа сурталчилж, шууд дамжуулалтаар лайв хийж 500 гаруй үзэгчдэд хүргэж хамтран ажиллалаа.



Хатан туул хамтлагийн бүжигчид олон нийтэнд бүжиг зааж, судлаач Амай аяллын тухай яриа хийж, Монгол бичгийн уран бичээч Г.Ганзориг бүтээлээ танилцуулж 400 гаруй иргэд олон нийтэд хүргэж хамтарч ажиллалаа.





"Загасан ширээт тамга" хамтлагын дуучин СТА Баатар, мөн чөлөөт уран бүтээлчид ковер дуу дуулан 200 гаруй иргэд, олон нийтэд хүргэв.



Гар барилдаан группын залуус аянд нэгдэж, Гар барилдааны спортыг 300 гаруй иргэд олон нийтэд сурталчилж хамтарч ажиллав.



Аяны хүрээнд хамтран ажиллагч Траст трейд компани Дансе чансе бүжгийн хамтлаг хамтран Хатаригш, Шарка Барка, Журай гэлдэн бүжгүүдийг сурах, Хэн шорлог хурдан идэх вэ? тэмцээн зохион байгуулж, үйл ажиллагааг шууд дамжуулалтаар 1600 гаруй иргэд, олон нийтэд сурталчилж ажиллалаа.



Мүүн дансе клубын дэргэдэх Мүүн дансе хамтлаг, Жи-рэбэл хамтлаг, Мүүн кидс хамтлагуудын бүжигчдийн үзүүлбэр, олон нийтэд бие биелгээ зааж 600 гаруй үзэгчдэд аяныг сурталчилж хамтран ажиллалаа.



“Хоггүй аялал гоё” аяны видео шторкийг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэж 2700 гаруй үзэгч, олон нийтэд хүргэж ажиллалаа.

“Хоггүй аялал гоё” аяныг нийт 10.000 иргэд олон нийтэд хүргэж, аяны хугацаанд аялал жуулчлалын салбарын иргэд, аж ахуйн нэгжийн 158 байгууллагын бараа, бүтээгдэхүүнийг сурталчилсан 2000 гаруй танилцуулга материал, “хоггүй аялал гоё” зурагт хуудас, наалт, номын хавчуурга, эко тор зэрэг бүтээгдэхүүн тарааж, 20 арга хэмжээ зохион байгуулж, нөлөөллийн аяныг олон нийтэд сурталчилж ажилласан болно.

#### ҮР ДҮН:

- Иргэдийн аялал жуулчлалын боловсролыг эрдэмтэн судлаач болон аялал жуулчлалын байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан сургалт зохион байгуулж, аяллаар явах үедээ түүхийн дурсгалт газруудаа үзэж судлах, байгаль орчинтой зүй зохистой харьцах, хог хаяхгүй байх, болзошгүй аюул, саад тотгор тулгарсан үед хэрхэн давж гарах зэрэг эерэг сэтгэлгээ, чадварыг суулгаж үлдээх,

- Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудын бараа бүтээгдэхүүнийг сурталчилан ямар аялалд ямар бүтээгдэхүүн хэрэглэх ёстойг тайлбарлан үндэсний үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн худалдан авалтыг нэмэгдүүлэх,

- Нийслэлийн бүс нутагт үйл ажиллагаагаа явуулдаг жуулчны бааз, амралтын газар, зочид буудал зэрэг аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудыг сурталчлан иргэдэд таниулах

- “Хоггүй аялал гоё” аяны хүрээнд “JCI Конгресс” Олон Улсын байгууллагатай хамтран Дэлхий даяар 180 оронд нэгэн зэрэг нэг цагт болох “World Cleanup Day” арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг хангаж тус аяны үйл ажиллагааг аялал жуулчлалын холбогдолтой 20 групп, фэйжүүдэд тараан сурталчлах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

#### **Гурав. УЛААНБААТАР ХОТЫН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗ, ЗОЧИД БУУДАЛ, ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД СТАНДАРТЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ**

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа амралтын газар, жуулчны баазуудад стандартын үзлэг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогчийн 2020 оны А997 дугаар захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу 8 ажлын хэсэг байгуулагдан 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд нийслэлийн 8 дүүргийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын



үйлчилгээ эрхэлж байгаа амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаанд стандартын үзлэг зохион байгуулж ажиллав.

**Хэрэгцээ шаардлага:** Нийслэлийн иргэд, төрийн бус байгууллагуудын санал, нийгмийн шаардлагын дагуу амралтын газар, жуулчны баазын үйл ажиллагаанд үндэсний стандартын хэрэгжилтийг бүрэн хангуулах, зах зээлд өрсөлдөх чадварыг нь сайжруулах, зочид, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, аюулгүй, амгалан тайван байдлыг хангасан, байгальд ээлтэй, эко шийдэлтэй ажил, үйлчилгээг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа.

**Үзлэг шалгалтын гол зорилго:** Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа амралтын газар, жуулчны баазуудыг бүртгэлжүүлэх, хууль тогтоомж, дүрэм журам, үйлчилгээний стандарт болон дэлхий нийтэд тархаж байгаа коронавирус /Ковид-19/ цар тахлын үеэр хэрэгжүүлэх Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 дүгээр түр журмын хэрэгжилтийг шалгаж, заавар зөвлөмж өгч ажиллах зорилготой.

**Төлөвлөлт:** Үзлэг шалгалтыг 2020 оны 7 дугаар сарын 27-31-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж, 144 амралт, жуулчны бааз, эрсдэлтэй 28 зочид буудал, 25 дэн буудлын буюу нийт 197 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулахаар төлөвлөсөн.

**Стандартын үзлэгийн Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд:**

- Нийслэлийн Аялал жуулчлалын газар
- Нийслэлийн Байгаль орчны газар
- Нийслэлийн Онцгой байдлын газар
- Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба
- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
- Нийслэлийн Цагдаагийн удирдах газар
- Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Налайх дүүргийн 6 дугаар хорооны засаг дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн албаны нийт 9 байгууллагын нийт 62 албан хаагчид ажиллалаа.



**Үзлэг шалгалтын үйл ажиллагаа:** Амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлын үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд нь Нийслэлийн




иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын дагуу амралтын газар, жуулчны баазын үндсэн шаардлага стандартыг хангаж Нийслэлийн Аялал жуулчлалын газраас зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлдэг.

Энэ удаагийн үзлэг шалгалтыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай” хууль, “Эрүүл мэндийн тухай” хууль, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангуулах тухай” хууль, “Галын аюулгүй байдлын тухай” хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хууль, “Захиргааны хариуцлагын тухай” хуулийн хүрээнд зохион байгуулж, “Амралтын газар, жуулчны баазуудад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага” MNS 4946:2019”, “Нүхэн жорлон угаадасны нүх. Техникийн шаардлага” MNS 5924:2015, Камерын иж бүрэн хэрэгсэл ерөнхий шаардлага MNS 6423:2013, “Ундны ус” MNS 900:2005, Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл MNS 5566:2005 стандартууд ба Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”, дэлхий нийтэд тархаж байгаа коронавирус /Ковид-19/ цар тахлын үеэр хэрэгжүүлэх Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 дүгээр түр журмын хэрэгжилт болон бусад холбогдох захирамжлалын баримт бичиг, дүрэм журмын хэрэгжилтийг шалгав.

Шалгалтад амралтын газар, жуулчны бааз 216, зочид буудал 9, дэн буудал 12 нийт 237 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хамрууллаа.

Арга хэмжээний үеэр Нийслэлийн хэмжээнд 216 амралт, жуулчны бааз үйл ажиллагаа явуулдаг болохыг бүртгэлжүүлж тогтоов. Бүртгэсэн 216 байгууллагаас 137 нь амралт, жуулчны бааз, 47 нь гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан бөгөөд 32 аж ахуйн нэгж нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

Үзлэг, шалгалтын явцад Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 дүгээр түр журмын хэрэгжилтийг 68 амралтын газар, жуулчны бааз хангаж, 78 амралт, жуулчны бааз боловсон бие засах газартай, үүнээс 3 амралт, жуулчны бааз саарал ус ашигладаг, 111 амралт, жуулчны бааз халаалтаа цахилгаанаар шийдсэн ба 73 амралт, жуулчны бааз зуухаар буюу ердийн галлагаатай үйл ажиллагаа явуулж, 52 амралт, жуулчны бааз MNS6043:2019 Амралтын газар, жуулчны баазын ерөнхий шаардлага стандартын шаардлага хангасан үйлчилгээ эрхэлж, 85 амралт, жуулчны бааз стандартын шаардлагыг хангаагүй үйлчилгээ эрхэлж байна. Стандартын шаардлага хангаагүй байгууллагуудаас 59 амралтын газар, жуулчны бааз Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2015 стандартын шаардлага хангаагүй, нийслэлийн хүн амын ундны усны эх Тэрэлж, Туул голын дагуу 47 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа нь илэрлээ. Дийлэнх амралт, жуулчны баазууд “Зочлох үйлчилгээний үндэсний стандарт, норм, норматив”, Гал түймрийн улсын хяналтын дүрэм зэрэг мэргэжлийн байгууллагуудаас гаргасан дүрэм, журмыг мөрдөөгүй, “Амралтын газар, жуулчны баазуудад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага” MNS 4946:2019”, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5283:2014, Камерын иж бүрэн хэрэгсэл ерөнхий шаардлага MNS 6423:2013/, “Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл MNS 5566:2005” стандартуудын шаардлагыг хангаагүй үйл ажиллагаа явуулж байлаа.



Шалгалтын явцад илэрсэн зөрчлүүд:

#### А. Аялал жуулчлалын чиглэлээр:

- “Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандартын шаардлагыг 75% нь хангахгүй,
- “Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандарт 2019 онд хүчингүй болсон. Налайх дүүргийн 6 дугаар хороо, Горхи тэрэлжийн байгалийн цогцолборт газарт 47 иргэн, байгууллага стандартад байхгүй гэр буудлын үйлчилгээ эрхэлж байна,
- Хүүхдэд зориулсан аюулгүй тоглоомын талбай, спорт талбай, аяллын хөтөлбөргүй
- Монгол Улсын стандартад байхгүй дагалдах үйлчилгээ эрхэлж байна. /дүүжин гүүр, зиплайн, ханан хаданд авирах, морь, мото унуулах үйлчилгээ/

#### Б. Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм журмын хэрэгжилтийн талаар:

- Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулаагүй,
- Аж ахуй нэгж, байгууллага, барилга, байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, нормыг хангаагүй,
- Барилга байгууламжид байх зөөврийн (гар) гал унтраагуурын нормын дагуу гал унтраагуурыг байрлуулаагүй,
- Цахилгаан тоног төхөөрөмж болон цахилгааны ерөнхий самбар, салбар /цит/-н дээр анхааруулах товъёог хийж байрлуулаагүй,
- Гал тогооны өрөөнд ус чийгээс хамгаалсан хамгаалалт байхгүй,
- Галын аюулгүй байдлын дүрэм гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө байхгүй,
- Байгууллага, аж ахуйн нэгж бүр галын анхан шатны багаж хэрэгслийн хадгалалт хамгаалалт, бэлэн байдал хариуцсан албан тушаалтныг томилж анхан шатны багаж хэрэгсэл нэг бүрийг хяналтын карттай болгож сар бүр үзлэг хийж чанар байдлын талаар тэмдэглэгээ хийнэ гэсэн заалтыг зөрчсөн,
- Аврах үйл ажиллагаа явуулах авралтын схем зураг, авралтын чиглэл заасан гэрэлт анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байхгүй,
- Цахилгааны утас газардуулгын системийг стандартын дагуу хийгээгүй,
- Цахилгаан тасармагц ослын тэжээлээс (өөр эх үүсвэрээс) тэжээгдэн автоматаар асч байхаар тоноглогдсон байна гэсэн заалтуудыг зөрчсөн,

- Эрчим хүчний мэргэжлийн байгууллагаар цахилгааны угсралтын зураг хийлгэж, шалгуулан дүгнэлт, баталгаа гаргуулаагүй,
- Ажилтнуудыг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх талаар ажил хийдэггүй, ажилтнуудын анхан шатны мэдлэг дутмаг,
- Аврах зам дахь хаалга нь дотор талаасаа түлхүүргүй чөлөөтэй онгойхоор байна гэснийг зөрчсөн гаднаасаа түгжээтэй түлхүүрийг байнгын бэлэн байдалд байлгаагүй,
- Галын сарайны иж бүрдэл дутуу, тэмдэг тэмдэглэгээ, хяналт бүртгэлийн карт хөтлөөгүй.
- Хийн тулгыг 2.2 метрээс дээш өндөр таазтай, агаар сорох суваг болон салхи оруулах цонхтой галлагаа хэрэглэдэггүй байранд барилгын халаах хэрэгслээс 1 метр, цахилгаан халаагчаас 3 метр зайтай байрлуулна гэснийг зөрчсөн,
- Цахилгааны шитны гал хамгаалагч хайрцаглаагүй, розетка, унтраалга, цахилгааны эх үүсвэрүүдийг хананаас шатдаггүй галд тэсвэртэй материалаар аюулгүйгээр суурилуулж тусгаарлаагүй, цахилгааны ил монтажтай утсыг механик гэмтлээс хамгаалж зориулалтын хамгаалалтын бүрхүүлд сүвлээгүй,
- Гал түймэр гарсан мэдээлэх холбоо дохиоллын хэрэгсэл байхгүй,
- Аврах зам дахь хаалга нь дотор талаасаа түлхүүргүй чөлөөтэй онгойхоор байна гэснийг зөрчсөн гаднаасаа түгжээтэй түлхүүрийг байнгын бэлэн байдалд байлгаагүй,
- Галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг биелүүлэх, галын аюулгүй байдлыг хариуцсан албан тушаалтныг томилоогүй,
- Налайх дүүргийн 6-р хороо, 2 дугаар хэсгийн Тэрэлж шугуйд 38 иргэн, аж ахуйн нэгж байгууллага үерийн усны аман дээр эрсдэлтэй газарт байрласан, ногоон байгууламж дээр цахилгааны утас татсан.

#### **В. Байгаль орчны талаар:**

- “Нүхэн жорлон, угаадасны нүх.Техникийн шаардлага MNS 5924:2015 стандарт”-ын шаардлагыг хангаагүй, хог хаягдлаа ил задгай хаяж байгаль орчинд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулж, орчны, хөрсний бохирдлыг их хэмжээгээр үүсгэж байгаа,
- Ой хээрийн түймрээс сэргийлэх, байгаль орчноо хамгаалах зэрэг мэдээллийн самбар байрлуулаагүй,
- Өөрийн байгууллагын орчинд эргүүл ажиллуулах, хяналт тавих ажил хийдэггүй.

#### **Г. Эрүүл ахуй, хүнсний чанар аюулгүй байдлын талаар:**


- Ажлын байрны дүгнэлт гаргуулаагүй,
- Холбогдох стандарт, дүрэм журмыг мөрддөггүй,
- Ажилчдад ажлын байрны тодорхойлолт гаргаж, танилцуулдаггүй,
- Ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаа байхгүй,
- Ажлын байран дээр ажилчдын бичиг баримт байхгүй болон нийтээрээ бичиг баримтын бүрдэл дутуу,
- Ажилчдаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулдаггүй,
- Тогтсон мэргэжлийн ажилчид байхгүй /Гэр бүлээрээ, насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулдаг/,
- Бохир орчинд хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг,
- Хүнсний түүхий эд хадгалалт, хамгаалалт хангалтгүй,
- Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хангалтгүй,
- Хөргөх, хөлдөөх төхөөрөмж хангалтгүй, ашиглалт муу,
- Ариутгал халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээг тогтмол хийдэггүй,
- Цагаан хэрэглэл угаах зориулалтын угаалгын газар байхгүй,
- Ажлын байр эмх цэгцгүй,
- Дүрэмт хувцас хэрэглэдэггүй,
- Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амрах нөхцөл алдагдсан,
- Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 дүгээр түр журмыг хэрэгжүүлж ажилладаггүй,
- Амрагчдад хоол ундаар үйлчилдэггүй,
- Стандарт хангахгүй гэрт зочдыг олноор оруулж архидах нөхцөлөөр хангадаг.



**Д. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар:**

- Мэргэжлийн байгууллагуудын зөвшөөрөл ажлын байранд байхгүй,
- Хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаггүй,
- Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангасан санамж, зөвлөмж, сэрэмжлүүлэг байршуулаагүй,
- Камержуулалт хангалтгүй,
- Харуул хамгаалалт байхгүй,
- Зочны бүртгэл хийдэггүй,
- Удирдлагууд нь ажлын байран дээрээ ажилладаггүй,
- Насанд хүрээгүй хүүхэд ажиллуулдаг зэрэг зөрчлүүд илэрлээ.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛҮҮД








Налайх дүүргийн 6 дугаар хороо, 2 дугаар хэсэг Тэрэлж шугуйд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж, байгаль орчинг бохирдуулсан байдал





Стандартын шаардлага хангахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагууд



Стандартын шаардлага хангахгүй, Монгол Улсад мөрдөх стандарт байхгүй дагалдах үйлчилгээ эрхэлсэн байдал






Газрын зөвшөөрлийг замбараагүй олгосноос Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт гэр хороолол буюу суурьшлын бүс болох нөхцөл бүрдсэн.

**Шалгалтын үеэр авсан арга хэмжээ:** Шалгалтын үеэр 216 амралт жуулчны баазыг мэдээллийн санд бүртгэж, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан 184 байгууллагад заавар зөвлөгөө өгч, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, стандартын шаардлага



хангаагүй үйлчилгээ эрхэлж байсан 86 байгууллагад Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын Мэдэгдэл хүргүүлэх тухай 2020 оны 01/255 дугаар албан бичгээр хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаагаа сайжруулах 14 хоногийн хугацаатай Мэдэгдэх хуудас өгч ажиллав. Мөн 4 байгууллагын галын аюулгүй байдлын дүгнэлтийг хурааж, үйлчилгээний чанар, стандарт хангаагүй “Монголхангай травел” ХХК-ийн “Булагтай” жуулчны бааз, “Бенибана” ХХК-ийн “Бенибана” амралт, “Хүүшийн оргил” ХХК-ийн “Цолмон” амралт, “Өрлөгт охин” ХХК-ийн “Түмэн үндэс” амралт, “Дэлгэрэх тэрэлж” ХХК-ийн “Дэлгэрэх” амралт, “Дөрвөн эрдэнэ тур” ХХК-ийн “Дөрвөн эрдэнэ” зэрэг амралтын газрын дотоод хяналтын журам мөрдөж ажиллаагүй зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалтаар тус бүр 1 сая төгрөгийн торгууль, “Цэлмэг Тэрэлж Алтай” ХХК-ийн “Хийлинг” амралтын газрын эрүүл ахуйн шаардлага, нөхцөлийг хангаагүй зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 6.17 дугаар зүйлийн 9 дэх заалтаар 500,0 төгрөгийн торгууль, иргэн Ч.Гэрэлт-Од нь /Шугуйн 39/, иргэн А.Цэндбаяр нь /Шугуйн 41/, иргэн Ц.Цэцгээ нь /Шугуйн 1-11/, иргэн Э.Чандманбаатар /Горхийн баруун салаа/ гэр амралтын газрын хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхдээ үйлдвэрлэлийн холбогдох дүрэм, журам, стандарт мөрдөөгүй зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйлийн 5.1 дэх заалтаар тус бүр 300,0 төгрөгөөр, нийт 11 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 7,700,000 төгрөгийн торгууль ногдуулав.

Шалгалтын ажлын явцыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээл, олон нийттэй харилцах хэлтсээр дамжуулан Ulaanbaatar.mn сайт болон телевиз, олон нийтийн цахим сайтуудаар мэдээлж ажиллав.



**Дүгнэлт:** Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа амралтын газар, жуулчны баазуудад стандартын үзлэг зохион байгуулах тухай Нийслэлийн засаг даргын хөгжлийн бодлогын асуудал хариуцсан Нэгдүгээр орлогч Ж.Батбаясгалангийн баталсан А/997 тоот захирамжийн дагуу Нийслэлийн Засаг дарга

бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр, сууцны үйл ажиллагаа эрхлэх журам болон амралтын газар жуулчны байгууллагуудын үйл ажиллагаанд тухайн төрөл, ангиллын улсын стандартын хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаад үнэлэлт дүгнэлт өгч, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх, дэмжлэг үзүүлэх зорилгоор Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа амралтын газар, жуулчны баазуудад стандарт үзлэг, шалгалтыг 2020 оны 08 сарын 01-ний өдрөөс 08 сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд Сүхбаатар, Чингэлтэй, Багануур, Налайх, Баянгол, Сонгинохайрхан, Хан уул, Баянзүрх дүүргүүдэд Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, дүүргүүдийн Засаг даргын тамгын газруудтай хамтран зохион байгуулж хийж гүйцэтгэсэн болно.

Стандарт үзлэг, шалгалтыг зохион байгуулахаас өмнө Нийслэлийн Аялал жуулчлалын газрын бүртгэлд Нийслэлийн хэмжээнд 144 амралт, жуулчны бааз бүртгэгдсэн байсан. Эдгээр амралт, жуулчны баазуудаас Нийслэлийн Аялал жуулчлалын газраас үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 37 аж ахуйн нэгж, байгууллага авсан байсан. Уг арга хэмжээний үеэр Нийслэлийн хэмжээнд 216 амралт, жуулчны бааз үйл ажиллагаа явуулдаг болохыг бүртгэлжүүлж тогтоов. Бүртгэсэн 216 байгууллагаас 137 нь амралт, жуулчны бааз, 47 нь гэр буудлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан бөгөөд 32 аж ахуйн нэгж нь ямар нэгэн байдлаар үйл ажиллагаа эрхлээгүй, үйл ажиллагаа эрхэлдэг эсэх нь тодорхой бус байв.

Үзлэг, шалгалтын явцад Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 дүгээр түр журмын хэрэгжилтийг 68 амралтын газар, жуулчны бааз хангаж, 78 амралт, жуулчны бааз боловсон бие засах газартай, үүнээс 3 амралт, жуулчны бааз саарал ус ашигладаг, 111 амралт, жуулчны бааз халаалтаа цахилгаанаар шийдсэн ба 73 амралт, жуулчны бааз зуухаар ердийн галлагаатай үйл ажиллагаа явуулж байна.

Үзлэг, шалгалтаар 52 амралт, жуулчны бааз MNS6043:2019 Амралтын газар, жуулчны баазын ерөнхий шаардлага стандартын шаардлага хангасан үйлчилгээ эрхэлж, 85 амралтын газар, жуулчны баазууд “Зочлох үйлчилгээний үндэсний стандарт, норм, норматив”, Гал түймрийн улсын хяналтын дүрэм зэрэг мэргэжлийн байгууллагуудаас гаргасан дүрэм, журмыг мөрдөөгүй, “Амралтын газар, жуулчны баазуудад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл үндсэн шаардлага” MNS 4946:2019”, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5283:2014, Камерийн иж бүрэн хэрэгсэл ерөнхий шаардлага MNS 6423:2013, “Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл MNS 5566:2005” стандартуудын шаардлагыг хангаагүй үйл ажиллагаа явуулж байлаа. Стандартын шаардлага хангаагүй байгууллагуудаас 59 амралтын газар, жуулчны бааз Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2015 стандартын шаардлага хангаагүй, нийслэлийн хүн амын ундны усны эх Тэрэлж, Туул голын дагуу 47 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа нь илэрлээ.

Нийслэл хотын хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа дийлэнх амралтын газар, жуулчны баазуудад хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй, стандарт мөрдөж ажилладаггүй байна. Аж ахуйн нэгж байгууллага /амралт, жуулчны бааз/ нь үйлчилгээний чанар, стандартад анхаарлаа хандуулдаггүй, ажилтнуудын дунд сургалт зохион байгуулдаггүй, мэдээ, мэдээлэл өгдөггүй, зөвхөн төр засагаас мэдээлэл өгөх, мэдлэг чадвар олгох ёстой мэтээр буруу ташаа ойлгодог.

Энэ нь төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо муу, хяналт шалгалт тогтмол хийдэггүй, аж ахуйн нэгж байгууллагуудыг мэдээллээр хангадаггүй, холбогдох дүрэм, журам, стандартын талаар сургалт семинар тогтмол явуулдаггүй нь үйлчилгээний чанар муу байх шалтгаан нөхцөл болж байна.

“Амралтын газар, жуулчны бааз, гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандарт 2019 онд хүчингүй болсон. Одоогийн байдлаар “Амралтын газар, жуулчны баазад тавих ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандартыг мөрдөн ажиллаж



байна. Зөвхөн Налайх дүүргийн 6 дугаар хороонд 47 гэр буудал үйл ажиллагаа явуулж байна. Энэ тоо цаашид нэмэгдэх төлөвтэй. Энд байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, даац хэтэрсэн нь Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа тухайн бүс нутагт газар олголтыг замбараагүй олгосонтой холбоотой гэж үзэж байна.

**Г/. Хөрөнгө, санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх санал, хүсэлт:**

**ЦААШИД:**

- Аялал жуулчлалын тухай хууль болон дагалдах Мэргэжлийн хяналтын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх
- Статистикийн тоо баримтад үндэслэн Улаанбаатар хотын аялал жуулчлалын стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулах
- Дүрмээр хүлээсэн үүргийг хангаж ажиллахад орон тоо, баталсан төсөв хүрэлцэхгүй байгаа
- Гэрээгээр ажиллаж байгаа албан хаагчдыг үндсэн бүтцэд оруулах шаардлагатай
- Салбарын онцлогоос хамааран /жуулчин жилийн өмнөх аялах шийдвэрээ гаргадаг/ зохион байгуулах эвент, оролцох үзэсгэлэнгийн хуваарийг НЗДТГ-аас жилийн өмнө тодорхой болгож өгөх
- Тогтмол зохион байгуулдаг арга хэмжээ, үзэсгэлэнгийн төсвийг байгууллагын төсөвт тусгуулах шаардлагатай.

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР